



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Хассуурийн ГАНХУЯГ

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 15 55, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: gankhuyagkh@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.08.21 № 411-03/9223
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл
өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Эдийн засгийн тусгай бүсийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн үзэл баримтлал, төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийн үзэл баримтлал, төслийг Монгол Улсын Их Хурлын холбогдох байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хавсралт 1/1 хуудастай.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Х. ГАНХУЯГ

О.АМГАЛАНБААТАР

Н.АЛТАНШАГАЙ

Д.БАТБАЯР

Р.БАТБОЛД

П.БАТЧИМЭГ

Ж.БАЯРМАА

Б.ЖАВХЛАН

Х.ЖАНГАБЫЛ

А. Шинэбаяр

2026000167



Ц.МӨНХБАТ

З.МЭНДСАЙХАН

Б.ПҮРЭВДОРЖ

П.САЙНЗОРИГ

Р.СЭДДОРЖ

Ч.УНДРАМ

Дав.ЦОГТБААТАР

2026000167



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Хассуурийн ГАНХУЯГ**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 15 55, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: gankhuyagkh@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

2026.08.14 № УИХ-03/9115
танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг төслийг санаачлан боловсруулж, өргөн мэдүүлэх тов тогтоолгох тухай албан бичгийг 2026 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн УИХ-03/7856 дугаарын албан бичиг, 2026 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн УИХ-03/8928 дугаар албан бичгийг тус тус хүргүүлсэн.

Дээрх асуудлаар Улсын Их Хурлын Тамгын газраас 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн ТГ-01/789 дугаарын албан бичиг, 2026 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн ТГ-02/880 дугаарын албан бичиг ирүүлсэн бөгөөд албан бичигт Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2-т заасны дагуу "...тухайн хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт..." орсон талаар дурджээ.

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 08 дугаар сарын 04-ны өдрийн ХЭГ/2637 дугаарын албан бичгээр ирүүлсэн санал, дүгнэлтэд хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орсон талаарх санал тусгагдаагүй байна. Гэсэн хэдий ч Улсын Их Хурлын Тамгын газраас ирүүлсэн албан бичгийн дагуу Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмыг үндэслэн хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан асуудлаар хуулийн төслийг шинэчилсэн найруулгын бүтцээр шинэчлэн боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх товыг тогтоож өгнө үү.

Хуулийн төслийн үзэл баримтлал, товч, дэлгэрэнгүй танилцуулга, холбогдох баримт бичгийг хавсаргав.

Хавсралт ²⁸⁷... хуудастай.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Х.ГАНХУЯГ

ТУС3764 9023051393 9087184

2026000155



2026.08.04 № ХЭГ/2637

Хуралдааны тэмдэглэл хүргүүлэх
тухай

Таны санаачлан боловсруулж Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлсэн Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хавсралт 6 хуудастай.



Монгол Улсын Засгийн газар
Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
Баттөмөр Энхбаяр
2026.08.04 18:28

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 27 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“21.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягаас санаачлан боловсруулсан Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгөх Засгийн газрын санал, дүгнэлт

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягаас санаачлан боловсруулсан Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгөх Засгийн газрын санал, дүгнэлтийн төслийг хэлэлцээд дараах саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухайд:

1.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эдийн засгийн тусгай бүсийн төрөл” гэсэн 4¹ дүгээр зүйл нэмж, “4^{1.1.1-4^{1.1.7}”-д “худалдааны чөлөөт бүс, аж үйлдвэрийн чөлөөт бүс, шинжлэх ухаан, технологийн чөлөөт бүс, боомтын чөлөөт бүс, аялал жуулчлалын чөлөөт бүс, тээвэр, логиستيкийн чөлөөт бүс, хөдөө аж ахуйн чөлөөт бүс”-ийн төрлийг тусгасан байна.}

Гэвч Чөлөөт бүсийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтад ““чөлөөт бүс” гэж гаалийн татвар болон бусад татварын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна оршиж байгаад тооцогдох, аж ахуйн үйл ажиллагааны тусгай дэглэм бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэсгийг”, мөн зүйлийн 3.1.11 дэх заалтад “эдийн засгийн хамтын ажиллагааны бүс” гэж хил залгаа улстай тус тусын хилийн зурвас дахь газарт Засгийн газар хоорондын хэлэлцээрт үндэслэн байгуулсан чөлөөт бүсийг” тус тус ойлгохоор тусгайлан тодорхойлсон байна.

Иймд “чөлөөт бүс”, “эдийн засгийн тусгай бүс”, “эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”, “боомтын чөлөөт бүс”, “хуурай боомт” зэргийн хамрах хүрээ, тодорхойлолт, эрх зүйн үр дагаврыг давхардуулахгүйгээр нэг мөр тодорхойлох;

2.Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан нэр томъёонь: өөрчлөлт нь Чөлөөт бүсийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтад заасан “гаалийн татвар болон бусад татварын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна оршиж байгаад тооцогдох” суурь агуулгыг өөрчлөх эрсдэлтэй байна.

Гаалийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт “Монгол Улсын чөлөөт бүсэд энэ хуульд зааснаас өөрөөр тогтоож болно” гэж, Чөлөөт бүсийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтад “...гаалийн татвар болон бусад татвараас хөнгөлөх, чөлөөлөх, шалган нэвтрүүлэх, бүртгэх, гаалийн хяналт тавих, чөлөөт бүсэд зорчих, хөдөлмөр эрхлэх хөнгөвчилсөн нөхцөлийн...тусгай зохицуулалтыг” чөлөөт бүсийн дэглэмд хамааруулан тус тус хуульчилсан.

Иймд энэ бүсийг гаалийн нутаг дэвсгэрээс гадна бүс гэж тооцох эсэх, тарифын болон тарифын бус хязгаарлалт, гаалийн хяналт, татвар ногдуулах, буцаан төлүүлэх үр дагаврын талаар хоёрдмол утгагүй хуулийн төсөлд нэг мөр тусгах;

3.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь хэсгээр Нэг цонхны үйлчилгээнд байгаль орчин, банк, банкнаас бусад санхүүгийн үйлчилгээ, барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуй, дэд бүтэц, зам, тээвэр, ...эрчим хүч зэрэг олон салбарыг хамааруулж, мөн хэсэгт "18.4.Энэ зүйлийн 18.3-т заасан чиглэлийн үйл ажиллагааны зөвшөөрлийг тухайлсан хуульд заасан тавигдах нөхцөл, шаардлагын дагуу чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно" гэж тусгасан байна.

Энэ нь Зөвшөөрлийн тухай хууль болон салбарт үйлчилж буй бусад хуулиудад заасан зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын бүрэн эрхтэй нийцэхгүй байна. Иймд зөвшөөрөл олгох бүрэн эрхийг шилжүүлэх бус, нэг цонхны үйлчилгээ нь хүсэлт хүлээн авах, дамжуулах, мэдээлэл солилцох, үйлчилгээний хугацааг хөнгөвчлөх зохион байгуулалтын шинжтэй үйл ажиллагаа байхаар тодорхой тусгах;

4.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь хэсгийн 18.3.13-т "эрчим хүч"-ийг нэг цонхны үйлчилгээнд хамааруулж, мөн хэсгийн 18.4-т уг чиглэлийн үйл ажиллагааны зөвшөөрлийг тухайлсан хуульд заасан тавигдах нөхцөл, шаардлагын дагуу чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно" гэж тусгасан байна.

Энэ нь Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 14 дэх хэсэгт тусгай зөвшөөрөл шаардах эрчим хүчний үйл ажиллагааг тусгайлан жагсаасан зохицуулалт, эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Эрчим хүчний зохицуулах хороо, аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлийн бүрэн эрхтэй нийцэхгүй байна.

Иймд хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь хэсгийн "18.4. Энэ зүйлийн 18.3-т заасан чиглэлийн үйл ажиллагааны зөвшөөрлийг тухайлсан хуульд заасан тавигдах нөхцөл, шаардлагын дагуу чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно" гэснээс эрчим хүчний тусгай зөвшөөрлийг чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгох хэсгийг хасах;

5.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь хэсэгт "18.3.2. банк, банкнаас бусад санхүүгийн үйлчилгээ"-г нэг цонхны үйлчилгээгээр үзүүлэхээр зохицуулсан бөгөөд мөн хэсгийн "18.4. Энэ зүйлийн 18.3-т заасан чиглэлийн үйл ажиллагааны зөвшөөрлийг тухайлсан хуульд заасан тавигдах нөхцөл, шаардлагын дагуу чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно" гэсэн байна. Энэ нь Банкны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-23.8 дахь хэсэгт банк байгуулах болон банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Монголбанк хянаж, шийдвэрлэхээр заасантай, мөн зүйлийн 23.1.5 дахь хэсэгт заасан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх шаардлагатай холбоотой зохицуулалттай нийцэхгүй байна.

Иймд банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг зөвхөн Монголбанк олгох, холбогдох хяналт шалгалт, эрсдэлийн үнэлгээний зохицуулалтыг хэвээр хадгалах;

6.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь хэсгийн "18.3.2. ...банкнаас бусад санхүүгийн үйлчилгээ"-ний хүрээнд үнэт цаас, даатгал, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, мөнгөн зээлийн үйл ажиллагаа зэрэг салбар хамаарах боломжтой байна. Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн

4.1 дэх хэсэгт “Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "Хороо" гэх/ нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн” гэж заасан.

Иймд банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний зөвшөөрөл, бүртгэл, хяналтыг Санхүүгийн зохицуулах хороо болон холбогдох эрх бүхий байгууллага хэрэгжүүлэх бүрэн эрхийг өөрчлөхгүйгээр хэвээр хадгалах;

7.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 14 дэх хэсэгт “25.1. Чөлөөт бүсэд үүссэн иргэний болон захиргааны маргааныг талуудын харилцан тохиролцоонд үндэслэн арбитрын журмаар шийдвэрлэнэ” гэж тусгажээ. Гэвч Арбитрын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Шүүхэд тусгайлан харьяалуулснаас бусад, арбитрын хэлэлцээрт тусгасан аливаа маргааныг арбитрын журмаар шийдвэрлэнэ” гэж заасан бөгөөд захиргааны акт, захиргааны гэрээ, нийтийн эрх зүйн маргаан нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар шүүхийн харьяалалд хамаарах тул захиргааны маргааныг арбитрын журмаар шийдвэрлэхээр ерөнхий тусгах нь шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хязгаарлах эрсдэлтэй.

Иймд арбитрын журмаар шийдвэрлэх маргааныг зөвхөн талуудын арбитрын хэлэлцээрт үндэслэсэн иргэний болон худалдааны шинжтэй маргаанаар хязгаарлах, захиргааны хэргийн маргааныг шүүхийн харьяалалд байхаар тусгах;

8.Чөлөөт бүсийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт “Чөлөөт бүс нь улсын онцгой объектод хамаарна” гэж, 25.2 дахь хэсэгт “Хилийн зурвас дахь чөлөөт бүсийн харуул хамгаалалтын үүргийг хил хамгаалах байгууллага, бусад чөлөөт бүсийн харуул хамгаалалтын үүргийг холбогдох байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр тус тус гүйцэтгэнэ” гэж, 25.3 дахь хэсэгт “Чөлөөт бүсэд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг цагдаа, дотоодын цэрэг гүйцэтгэнэ” гэж тус тус заасан байна.

Ийнхүү чөлөөт бүсийг улсын онцгой объектод хамааруулж, хилийн зурвас дахь чөлөөт бүсийн харуул хамгаалалтын үүргийг хил хамгаалах байгууллагад хариуцуулах одоогийн хуулийн зохицуулалттай уялдуулан, хуулийн төсөлд хил хамгаалах байгууллагын шалган нэвтрүүлэх, бүртгэх, мэдээлэл солилцох, түр саатуулах, үзлэг хийх, хөдөлгөөн түр хязгаарлах, хил зөрчигчийг эрэн сурвалжлах, онцгой нөхцөлд тусгай дэглэм тогтоох эрх, чиг үүргийг хэрэгжүүлэх үндэслэл, нөхцөл, журам, хугацаа, хяналт, хүний эрхийн баталгааг Монгол Улсын хилийн тухай хууль болон холбогдох процессын хууль тогтоомжтой уялдуулах;

9.Чөлөөт бүсийн харуул хамгаалалт, шалган нэвтрүүлэх үйл ажиллагааг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай техник хэрэгсэл, мэдээллийн системийг суурилуулах, эзэмших, ашиглах, засвар, үйлчилгээ хийх, санхүүжүүлэх эх үүсвэр, мэдээлэл хариуцах этгээд, мэдээллийн нууцлал, хамгаалалт, хандалтын эрх, хяналт тавих байгууллагын чиг үүргийг тодорхой тусгаагүй нь чөлөөт бүсийн тусгай дэглэмийн хэрэгжилт, харуул хамгаалалт, шалган нэвтрүүлэх болон хяналтын тогтолцоог сулруулах эрсдэлтэй байна.

Иймд чөлөөт бүсийн аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх ажиллагаанд ашиглах техник хэрэгсэл, цахим системийн санхүүжилтийн эх үүсвэр, ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээ, мэдээлэл хариуцах этгээд, мэдээллийн аюулгүй байдал, хяналт, хариуцлагын зохицуулалтыг хуульд тодорхой тусгах;

10.Гаалийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт “Монгол Улсын чөлөөт бүсэд энэ хуульд зааснаас өөрөөр тогтоож болно” заасан боловч энэ нь гаалийн байгууллагын хяналтын бүрэн эрхийг үгүйсгэх үндэслэл болохгүй. Монгол Улсын нэгдэн орсон Гаалийн бүрдүүлэлтийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын конвенц буюу шинэчлэн найруулсан Киотогийн конвенцын тусгай хавсралт D-ийн 2 дугаар бүлэг (Чөлөөт бүс)-ийн Стандарт 4-т гаалийн байгууллага чөлөөт бүсэд байгаа барааг аль ч үед шалгах эрхтэй байна гэж заасан. Мөн Чөлөөт бүсэд тавих гаалийн хяналт нь гаалийн (баталгаат) агуулахад тавьдаг хяналтыг бодвол илүү уян хатан байх бөгөөд холбогдох бичиг баримтын шалгалтаар хязгаарлагдана.

Иймд Монгол Улсын нэгдэн орсон шинэчлэн найруулсан Киотогийн конвенцын тусгай хавсралт D-ийн 2 дугаар бүлэг (Чөлөөт бүс)-ийн Стандарт 4-т заасан “Гаалийн байгууллага чөлөөт бүсэд байгаа барааг аль ч үед шалгах эрхтэй байх” гэсэн хэсэгт нийцүүлж гаалийн шалгалт хийх зохицуулалт тусгах;

11.Хуулийн төсөлд чөлөөт бүсэд нэвтрэх иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг цахим хэлбэрээр бүртгэх, таних, баталгаажуулах, биометрик мэдээлэл ашиглах зохицуулалт тусгахдаа Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан хүний эмзэг мэдээлэл, биометрик мэдээлэл боловсруулах үндэслэл, зөвшөөрөл, зорилго, хамрах хүрээ, хадгалах хугацаа, хандалтын эрх, устгал, мэдээллийн эзний эрх, гуравдагч этгээдэд дамжуулах хоригийг тодорхой тусгах шаардлагатай.

Мөн Кибер аюулгүй байдлын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан төрийн мэдээллийн систем, мэдээлэл солилцоо, хамгаалалтын шаардлагад нийцүүлэх;

12.Хуулийн төсөлд чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, бүртгэл, гэрчилгээ олгох зохицуулалт тусгагдсан боловч зөвшөөрлийн нөхцөл зөрчсөн, гаалийн болон татварын зөрчил удаа дараа гаргасан, санхүүгийн, байгаль орчны, хөдөлмөрийн, мэдээллийн аюулгүй байдлын шаардлага хангаагүй тохиолдолд үйл ажиллагааг түдгэлзүүлэх, зөвшөөрөл, бүртгэлийг сунгахгүй байх, хүчингүй болгох, эдэлсэн татвар, гаалийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг нөхөн төлүүлэх зохицуулалт тодорхойгүй байна.

Иймд Зөвшөөрлийн тухай хууль болон салбарын хуульд заасан зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох нийтлэг зарчимтай нийцүүлэн холбогдох этгээдийн тусгай дэглэмд эдлэх эрх, хариуцлагыг хамтад нь хуульчлах;

13.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “6.3. Чөлөөт бүсийг төрөл, чиглэлээс хамааран 20 жилээс багагүй хугацаатай байгуулж болно” гэсэн нь хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангах ач холбогдолтой ч тухайн бүс зорилгодоо хүрээгүй, үр ашиггүй ажилласан, төсөв, татвар, газар, дэд бүтэц, хяналт, хууль сахиулах байгууллагын ачааллыг нэмэгдүүлсэн эсэхийг үнэлэх, өөрчлөх, шаардлагатай бол тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахгүй байх, эсхүл татан буулгах шалгуур, журмыг тодорхой тусгаагүй байна.

Иймд чөлөөт бүсийн үр дүнг хөрөнгө оруулалт, ажлын байр, экспорт, төсвийн нөлөө, дэд бүтцийн ашиглалт, байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, авлигын эрсдэл, хууль сахиулах болон хяналтын ачааллын үзүүлэлтээр тодорхой цаглаврын дагуу үнэлж, уг үнэлгээнд үндэслэн сунгах, өөрчлөх, татан буулгах шийдвэр гаргах зохицуулалтыг тусгах;

14.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “6.7.Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан энэ хуулийн 4¹ дүгээр зүйлийн 4^{1.1}-д зааснаас өөр төвлөрсөн чөлөөт бүсийг байгуулж болно” гэж тусгасны “өөр төвлөрсөн чөлөөт бүс”, “бусад төрөл” гэх нийтлэг томъёолол нь эрх зүйн тодорхой байдлын зарчим, татвар, гааль, зөвшөөрөл, хөдөлмөр, байгаль орчны тусгай дэглэмийн хязгаарыг тодорхойгүй болгох эрсдэлтэй тул чөлөөт бүсийн төрөл, байгуулах үндэслэл, шалгуур, шийдвэр гаргах субъект, хяналтын хэлбэр, эрх зүйн үр дагаврыг тодорхой тогтоох;

15.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 12 дахь хэсэгт тусгасан “Хөрөнгө оруулагчдын зөвлөл” нь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих, зөвлөлдөх, санал өгөх, мэдээлэл солилцох чиг үүрэг бүхий механизм байх нь зүйтэй бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүн, бүрэн эрх, үйл ажиллагааны хэлбэр, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зохицуулалт, гаргах шийдвэрийн эрх зүйн үр дагаврыг тодорхой зохицуулаагүй тохиолдолд төрийн бодлого боловсруулах, зөвшөөрөл олгох, хяналт хэрэгжүүлэх зэрэг нийтийн эрх зүйн чиг үүрэг хувийн хэвшилд шилжих, эсхүл тодорхой хөрөнгө оруулагч, аж ахуйн нэгжид давуу байдал бий болох, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлтэй байна.

Иймд хөрөнгө оруулагчдын зөвлөлийн шийдвэр нь зөвлөмжийн шинжтэй байх, зөвлөлийн бүрэлдэхүүн төр, хувийн хэвшил, мэргэжлийн байгууллага, шаардлагатай тохиолдолд орон нутгийн төлөөллийн тэнцвэрийг хангах, гишүүд ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэг гаргах, хуралдааны тэмдэглэл, санал, зөвлөмжийг ил тод мэдээлэх, зөвлөлийн үйл ажиллагаанд тавих хяналт, хариуцлагын зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах;

16.Хуулийн төсөлд нэгдсэн захиргаа, захирагчийн ажлын алба, чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орон нутгийн захиргаа болон гааль, хил хамгаалах, цагдаа, тагнуул, татвар, улсын бүртгэл, хяналт хэрэгжүүлэх байгууллагын чиг үүргийг тусгахдаа тухайн байгууллага тус бүрийн шийдвэр гаргах эрх хэмжээ, мэдээлэл солилцох журам, хяналт шалгалт хэрэгжүүлэх хүрээ, хариуцлага тооцох заагийг тодорхой болгох шаардлагатай. Өөрөөр хэлбэл, бүрэн эрх давхардах, байгууллага хоорондын уялдаа алдагдах, хариуцлага эзэнгүйдэх, захиргааны шийдвэрийн хууль зүйн үндэслэл маргаантай болох эрсдэлтэй тул Захиргааны ерөнхий хууль болон салбарт үйлчилж буй холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн байгууллага бүрийн чиг үүрэг, эрх хэмжээ, хамтран ажиллах зохицуулалтыг хуулийн төсөлд бүрэн тусгах.

Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дагалдах бусад хуулийн төслийн тухайд:

1.Хот байгуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад заасан “чөлөөт бүсийн хилийн цэсийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах” Улсын Их Хурлын бүрэн эрхийг хасаж, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь заалтад “чөлөөт бүс, эдийн засгийн чөлөөт бүсийн хилийн цэс, байршлыг баталж, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж Засгийн газрын бүрэн эрхийг шинээр нэмэхээр тусгасан байна.

Энэ нь Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтад “газар төрийн хяналт, хамгаалалтад байх” гэж заасан төрөөс газрын талаар баримтлах зарчим, мөн хуулийн 8.2 дахь хэсэгт заасан “хилийн цэс, газар усны нэрийг Улсын Их Хурал ... батална” гэж заасантай зөрчилдөж байна;

2.Хуулийн төсөлд Хот байгуулалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалтын “чөлөөт бүс, аялал, жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, ерөнхий төлөвлөгөө” гэснээс “чөлөөт бүс” гэснийг хасахаар тусгасан байна. Иймд чөлөөт бүсийн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ, зам тээвэр, барилга байгууламж, үйлчилгээний төлөвлөлтийг хот байгуулалтын шаардлагаас ангид ойлгох боломжгүйг анхаарч “чөлөөт бүс” гэсэн нэр томъёог хасах гэснийг нягтлах;


3.Хуулийн төсөлтэй холбогдуулан Зөвшөөрлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэгт чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт үйлчлэх тусгай дэглэм, зөвшөөрөл олгохтой холбогдох харилцааг тус хуулийн үйлчлэлд хамаарахгүй байх нэмэлт оруулахаар тусгасан нь зөвшөөрлийн нэгдсэн тогтолцоо, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, бүртгэл мэдээллийн сан, хяналт, хариуцлагын механизмыг бүхэлд нь сулруулах эрсдэлтэй юм.

Иймд Зөвшөөрлийн тухай хуулийн үйлчлэлээс бүхэлд нь гаргах бус, зөвхөн тусгай дэглэм шаардлагатай тодорхой төрөл, нөхцөл, хязгаарын хүрээнд тусгай зохицуулалт хийх;

4.Эдийн засгийн тусгай бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах шийдвэр гаргахаас өмнө тухайн бүсийн эдийн засаг, төсөв, татвар, газар, дэд бүтэц, байгаль орчин, орон нутгийн хөгжил, авлига, үндэсний аюулгүй байдал, хууль сахиулах болон хяналтын байгууллагын ачаалалд үзүүлэх нөлөөллийг урьдчилан судалсан байх шаардлагатай. Мөн орон нутгийн иргэд, нутгийн өөрөө удирдах байгууллага, холбогдох төрийн байгууллага, хувийн хэвшлийн саналыг авах журмыг тодорхой болгож, уг судалгаа, санал авах ажиллагаа, хэрэгжилтийн үе шат, хариуцах байгууллага, зардлын эх үүсвэр, хяналт-шинжилгээ, үнэлгээний зохицуулалтыг дагаж мөрдөх журмын тухай хууль болон холбогдох дагалдах хуулийн зохицуулалтад тусгах;

5.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ажиллах хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн гарчиг, агуулгыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэгт заасан “нэмэлт оруулах тухай”, “өөрчлөлт оруулах тухай”, “нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “хүчингүй болсонд тооцох тухай” гэх шаардлагад нийцүүлэх, мөн хууль хэрэгжиж эхлэх, дагаж мөрдөх хугацааг үндсэн төсөлтэй уялдуулан тодорхой заах;

6.Хуулийн төслийн үзэл баримтлал, дэлгэрэнгүй танилцуулгад Зөрчлийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Татварын ерөнхий хууль болон бусад хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай талаар дурдсан боловч дагалдах хуулийн төслүүдэд эдгээр хуулийн төслүүдийг хавсаргаагүй байгааг анхаарах.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**БАТЛАВ.
УЛСЫН ИХ ХУРИЙН
ГИШҮҮН**

Х.ГАНХУЯГ

2026 оны 08 сарын 13-ны өдөр

**ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлаас “Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал”-ыг 1995 онд, Чөлөөт бүсийн тухай хуулийг 2002 онд, Чөлөөт бүсийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 онд баталсан байна.

Чөлөөт бүсийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хэрэгжиж эхэлснээс хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд 12 удаагийн нэмэлт, өөрчлөлт орсон байх бөгөөд худалдааг хөнгөвчлөх, чөлөөт бүсийг нээх, хаахтай холбогдсон харилцаа, гадаадаас ажиллах хүч авахтай зохицуулалт, согтууруулах ундаа, тамхи худалдах зөвшөөрлийн харилцааг зохицуулжээ.

Чөлөөт бүсийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, худалдааны урсгалыг бий болгох, чөлөөт бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хил орчмын худалдаа, эдийн засгийн харилцаанд гарч буй өөрчлөлт, шинэчлэлт, чөлөөт бүсийн хөгжлийн орчин үеийн чиг хандлага болон Монгол Улсын онцлог, эрх ашигт нийцүүлэн чөлөөт бүсийн хууль, эрх зүйн орчныг дахин өөрчлөх шаардлага гарч байгааг хуулийн төслийн танилцуулгад дурдсан байх бөгөөд¹ хуулиар чөлөөт бүсийн тодорхойлолт, чөлөөт бүс байгуулах зорилго, чөлөөт бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах харилцаа, чөлөөт бүсийн удирдлага, чөлөөт бүс дэх гааль, татвар, виз, хуулийн этгээдийн бүртгэл, төлбөр тооцоо, хөдөлмөр эрхлэлтийн талаарх тусгай дэглэм, чөлөөт бүсэд эрхлэх үйл ажиллагааны төрөл, чөлөөт бүсийн газрын харилцаа, дэд бүтэц, харуул хамгаалалт зэрэг асуудлыг зохицуулсан байна.

Чөлөөт бүсийн үйл ажиллагаанд хуулиас гадна 10 гаруй дүрэм, журмыг эрх бүхий байгууллагаас батлан мөрдүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Зорилт 9.5-д “Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, худалдаа, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд Азийн тээвэр, логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлэх” гэж, Монгол Улсыг 2021-2025 оны хооронд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн 3.1.17-д “Чөлөөт бүсүүдийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, экспорт болон дотоодын зах зээлд чиглэсэн худалдаа, үйлчилгээ, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж,

¹ “Чөлөөт бүсийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн танилцуулга” /2014.06.12-ны өдөр ЗГ-аас УИХ-д өргөн мэдүүлсэн/.

гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжиж ажиллана” гэж бодлогын баримт бичигтээ чөлөөт бүсийг хөгжүүлэх гэж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.2.2.1-д “Аялал жуулчлал, тээвэр, логистик, олон улсын санхүүгийн төв, эдийн засгийн чөлөөт бүс бүхий эко-ухаалаг Хүннү дагуул хотын бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг үе шаттайгаар шийдвэрлэж, дулааны станц, цэвэрлэх байгууламжийн дэд бүтцийг барьж байгуулна” гэж, 1.2.2.5-д “Хүннү хот дахь чөлөөт бүсийг тулгуурлан “Цахиурын хөндий” дата төв хүлэмжийн болон сэргээгдэх эрчим хүчний хосолсон загвар аж ахуйг хөгжүүлнэ” гэж, 1.3.5.4-т “Хөшигийн хөндий болон Алтанбулаг чөлөөт бүсэд ачаа тээвэр, барилгын материалын логистикийн төв байгуулна” гэж, 1.4.1.6-д “Орон нутагт чөлөөт бүс, тусгай бүс, аж үйлдвэрийн парк байгуулж боомт, хөрш орны хотуудтай холбоно” гэж, 3.2.2.11-д “Бүсүүдийн тэргүүлэх чиглэл, онцлог, нөөц, байршлын давуу талд тулгуурлан эдийн засгийн тусгай бүсийг байгуулж, одоо байгаа татварын хөнгөлөлт бүхий чөлөөт бүсүүдийн бүрэн ашиглалтад оруулна” гэж, 3.2.2.12-т “Чөлөөт бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн болон нарийвчилсан төлөвлөгөөнүүдэд тодотгол хийж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, чөлөөт бүсийн хууль, эрх зүйн орчныг шинэчилнэ” гэж, 3.3.5.5-д “Түүх, соёл, байгалийн үзэсгэлэнт газрын нөөц, археологи, палеонтологийн нөөцөд тулгуурласан аялал жуулчлалын чөлөөт бүс байгуулж, жуулчдын нэвтрэх урсгалыг нэмэгдүүлнэ” гэж, 3.3.7.4-т “Мэдээллийн технологи, судалгаа хөгжүүлэлт, инновацын үйл ажиллагаа эрхлэх татварын хөнгөлөлттэй чөлөөт бүс, шинжлэх ухааны паркийг хөгжүүлнэ” гэж, 4.4.2.14-т “Чөлөөт бүсүүдэд бизнес инкубатор төвийг байгуулж, гадаад худалдааны түүхий эд, технологийн солилцоогоор аж ахуй эрхлэгчдийг дэмжинэ” гэж тус тус бодлогын баримт бичигт чөлөөт бүсийг хөгжүүлэх талаар тусгажээ.

1.2.Практик шаардлага

Дэлхийн эдийн засгийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцүүлэн эдийн засгийнхаа эргэлтийг сайжруулан улс орны хөгжлийг хурдасган өсөлтийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Монгол Улсын Их Хурал 2002 оны 38 дугаар тогтоолоор “Алтанбулаг чөлөөт бүс байгуулах тухай”, 2004 оны 17 дугаар тогтоолоор “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс, 2005 оны 74 дүгээр тогтоолоор “Цагаан нуур” худалдааны чөлөөт бүс, 2022 оны 10 дугаар тогтоолоор “Хөшигийн хөндий эдийн засгийн чөлөөт бүс” байгуулахаар шийдвэрлэж, чөлөөт бүсийн газрын талбайн хэмжээ, газрын байршил, хилийн заагийн эргэлтийн цэгийн солбицлыг тогтоожээ.

Манай улсад чөлөөт бүсийн үзэл баримтлал, хууль эрх зүйн орчин бүрэлдээд арав гаруй жил өнгөрч, энэ хугацаанд улсын төсвөөс нэлээд хөрөнгө оруулсан ч тодорхой үр дүнд хүрч чадахгүй байна.

Монгол Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д эхний ээлжинд ОХУ-тай хил залгаа “Алтанбулаг”, “Цагааннуур”, БНХАУ-тай хил залгаа “Замын-Үүд” боомтод түшиглэн худалдаа, гаалийн тусгай /чөлөөт/ бүсүүд байгуулж, олон улсын жишгийн дагуу уг бүсүүдийн хүрээнд дотоод, гадаадын худалдаа эрхлэгчид, хөрөнгө оруулагчид харилцан ашигтай, хамтран ажиллах бизнесийн орчныг бүрдүүлэх, зохих туршлага бүрдмэгц Монгол Улсын нутаг дэвсгэрийн гүнд тусгай /чөлөөт/ бүсийг зохистой төрөл,

чиглэлээр байгуулах ажлыг өргөжүүлэх зорилтын хүрээнд “Алтанбулаг”, “Замын-Үүд”, “Цагааннуур” чөлөөт бүсийг байгуулсан.

Гэвч “Алтанбулаг”, “Замын-Үүд”, “Цагааннуур”-ын чөлөөт бүсүүдийн одоогийн үйл ажиллагаа нь чөлөөт бүсийн хөгжил, түүнийг дагасан хотжилт, бүтээн байгуулалт, үйлдвэржилтийн талаар тодорхой ахиц үгүй, эдийн засагт тус нэмэр болох тухай анхны зорилтууд нь хэрэгжээгүйгээс эдгээр чөлөөт бүсүүд үр ашиггүй гэж нэрлэгдэх болж байна.

Иймд чөлөөт бүс нь улсын төсвөөр тэтгүүлдэг биш өөрөө өөрийгөө санхүүжүүлээд зогсохгүй улсын төсөвт хөрөнгө төвлөрүүлдэг газар болгож өөрчлөх зарчмын үндсэн дээр эрх зүйн орчныг улс орны хөгжлийн өнөөгийн шаардлага, хэтийн чиг хандлага, тэргүүлэх туршлагад нийцүүлэн боловсронгуй болгох шаардлагатай байна.

2024 оны байдлаар дэлхийн 145 улсад 5400 орчим эдийн засгийн тусгай бүс /ЭЗТБ/ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээр нь ойролцоогоор 500-600 тэрбум ам.долларын экспортын бараа бүтээгдэхүүний эргэлт хийж, 100 сая хүнийг ажлын байраар хангаж байна.²

Чөлөөт бүсийн тодорхойлолт

Чөлөөт бүсийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т “чөлөөт бүс гэж гаалийн татвар болон бусад татварын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна оршиж байгаад тооцогдох, аж ахуйн үйл ажиллагааны тусгай дэглэм бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэсгийг ойлгоно” гэж тодорхойлсон бөгөөд Хүннү хотын эрх зүйн байдлын тухай, Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулиудад “Чөлөөт бүс”, “Эдийн засгийн чөлөөт бүс”, “Эдийн засгийн тусгай бүс”, “Олон улсын санхүүгийн төв” гэх мэт ялгаатай нэршлээр ижил чиг үүрэг бүхий зорилгыг давхардуулан тусгасан нь ойлгомжгүй байдлыг бий болгож, хууль хоорондын давхардал, зөрчил үүсгэж байна.

Өөрөөр хэлбэл Хөшигийн хөндийн чөлөөт бүсэд Хүннү хотын эрх зүйн байдлын тухай хууль давуу үйлчлэх үү, Чөлөөт бүсийн тухай хууль давуу үйлчлэх үү, эсхүл Хүннү хотын эрх зүйн байдлын тухай хууль нь ерөнхий хуулийн байдлаар үйлчилж, Чөлөөт бүсийн тухай хууль нарийвчилсан хууль болж үйлчлэх эсэх зэрэг хууль зүйн хувьд тодорхой болгох, ойлголтоо нэгтгэх шаардлагатай тулгарч байна.

Ийнхүү чөлөөт бүс гэх ойлголтын тодорхойгүй байдалтай холбоотойгоор чөлөөт бүсийн дэглэмийг тодорхойлох асуудал нь хууль зүйн хувьд тодорхойгүй хэвээр байна. Иймээс чөлөөт бүсийн төрөл, хэлбэр, тусгай дэглэмийн талаар нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

Олон улсын эрх зүйн харьцуулалтын хүрээнд авч үзвэл дэлхийн улс орнууд, тухайлбал, Япон, Индонези, Филиппин, Мьянмар, Камбож зэрэг улсууд чөлөөт бүсийн тухай хуулиа “Эдийн засгийн тусгай бүсийн тухай” буюу Special economic zone гэж нэрлэсэн байх ба тусгай бүс нь чөлөөт худалдааны, экспорт боловсруулалтын, эдийн

² UNCTAD. World Investment Report 2024: Special Economic Zones. United Nations Conference on Trade and Development, Geneva, 2024.

засгийн, аж үйлдвэрийн, эдийн засгийн хамтын ажиллагааны зэрэг чөлөөт бүсийн төрлүүдийг өөртөө багтаасан өргөн хүрээтэй ойлголт байна.

Манай улсын хувьд нийт 6-н /Улсын Их Хурлын тогтоолоор 4, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор 2/ чөлөөт бүс байгуулсантай холбоотой "Чөлөөт бүсийн тухай" хуулиа "Эдийн засгийн тусгай бүсийн тухай" гэж өөрчилснөөр бүх төрлийн чөлөөт бүсэд үйлчлэх боломжтой эрх зүйн зохицуулалт гэж ойлгож болохоор юм.

Чөлөөт бүсийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалт, 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэг нь бусад чөлөөт бүс гэх ойлголтоос ялгамжтай байдлаар буюу эдийн засгийн хамтын ажиллагааны бүс гэх нэршлийг тодорхойлсон байгааг мөн Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 39.1-т "Тусгай бүс байгуулах чиглэл" гэж зааснаас үзвэл чөлөөт бүсүүдийн зорилго, төрлийн хувьд өөр өөр болохыг, мөн чөлөөт бүсэд тодорхой нэг нэгдсэн нэршил, зохицуулалт шаардлагатай болохыг харуулж байна.

Дэлхийн олон улсын судалгаанд эдийн засгийн тусгай бүсийг хөгжлийн үе шатны хувьд SEZ 1.0, SEZ 2.0, SEZ 3.0 гэсэн ангиллаар авч үздэг бөгөөд Монгол Улсад хэрэгжиж буй чөлөөт бүсүүд нь үндсэндээ SEZ 1.0 болон SEZ 2.0 үе шатны онцлогтой гэж үзэж болно. Тухайлбал, Алтанбулаг, Замын-Үүд, Цагааннуур зэрэг чөлөөт бүсүүд нь худалдаа, үйлчилгээ, логистик болон экспортын үйл ажиллагааг дэмжих зорилготой байгуулагдсан бөгөөд татвар, гаалийн хөнгөлөлтөөр дамжуулан гадаад худалдааг өргөжүүлэхэд чиглэсэн уламжлалт бүсийн шинжийг агуулж байна. Энэ нь экспортын үйлдвэрлэл, худалдааг дэмжих зорилготой SEZ 1.0 загвартай нийцэж байгаа бөгөөд цаашид SEZ 3.0 загварт шилжих шаардлагатай байгааг судалгаанд дурдсан байна.

Чөлөөт бүсийн төрөл, хэлбэр

2015 онд батлагдсан Чөлөөт бүсийн хуулийн зорилт нь “чөлөөт бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах, түүний байршил, удирдлагын эрх хэмжээ, хяналтын тогтолцоо, чөлөөт бүсэд мөрдөх татвар, гааль, шалган нэвтрүүлэх, хуулийн этгээдийн болон иргэний бүртгэл, хөдөлмөр эрхлэлтийн тусгай дэглэмийн эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж, хуулийн зорилго нь “тухайн бүсэд эрх зүй хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлснээр иргэн, аж ахуйн нэгжийн экспорт, импортыг дэмжих, экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, худалдаа, үйлчилгээний шинэ салбар, аялал жуулчлал, хөрөнгө оруулалтыг татах, транзит тээвэр, логистикийг нэмэгдүүлэх, тэргүүний техник, технологийг нутагшуулах, худалдааг хөнгөвчлөх, бүс нутгийн хөгжлийг хурдасгах замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд оршино” гэж тодорхойлсон бөгөөд чөлөөт бүсийн төрөл, хэлбэрийг өөрөөр нарийвчлан хуульчлаагүй байна.

Дэлхийн чөлөөт бүсүүдийн ерөнхий хандлага худалдаанд суурилсан бүсээс илүү техник технологид түшиглэсэн, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгохыг зорилго болгосон бүсүүдийг хөгжүүлэхэд чиглэж байгаа бөгөөд худалдааны чөлөөт бүс, экспортыг дэмжих бүс, аж үйлдвэрлэлийн тусгай бүс, далайн тээврийн тусгай боомт, шинжлэх ухаан/технологийн парк, хими технологийн бүс, тээвэр логистикийн төв, санхүүгийн чөлөөт бүс, нисэх буудал тойрсон тээвэр логистик, гаалийн тусгай бүс зэрэг үйл ажиллагааны чиглэлийн хувьд ялгаатай,

төрөлжсөн болон нийтлэг үйл ажиллагаа бүхий чөлөөт бүсүүдийг газар нутгийнхаа байрлал, онцлог, дэд бүтцийн нөхцөл байдал, хүрээлэн буй орчин, байгалийн нөөц боломждоо тулгуурлан өөрийн орны эдийн засгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн улс орон бүр өөрийн бодлогоор тодорхойлж байна.

Олон улсад эдийн засгийн тусгай бүсийг зорилго, үйл ажиллагааны чиглэлээс нь хамааран чөлөөт худалдааны бүс, экспорт боловсруулах бүс, аж үйлдвэрийн парк, шинжлэх ухаан технологийн парк, нэгдсэн тусгай бүс гэсэн үндсэн төрлүүдэд ангилдаг байна.³

Чөлөөт бүсийг байгуулах, өөрчлөх, татан буулгах, түүний хилийн цэс, байршлыг тогтоох

Чөлөөт бүсийн хуулиар чөлөөт бүс байгуулах өөрчлөх, татан буулгах, түүний хилийн цэс, байршлыг тогтоох, асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал гаргах бүрэн эрхтэй бөгөөд Засгийн газраас санал болгосон хилийн бүсэд чөлөөт бүс байгуулахаар тусгажээ. Түүнчлэн, чөлөөт бүсийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах асуудал, бүсийн байршил, хилийн заагийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно гэжээ. Харин хил дамнасан чөлөөт бүсийг Засгийн газар хоорондын хэлэлцээрээр байгуулж, бодлого, үйл ажиллагаагаа эдгээр хэлэлцээрээр зохицуулж болно. Үүнээс үзвэл чөлөөт бүсийг байгуулах, татан буулгах асуудлыг Улсын Их Хурал хэрэгжүүлэхээр зохицуулжээ.

Гэвч Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулагдах үйл явц төдийлөн амжилттай хэрэгжиж чадахгүй байгаагийн улмаас олон нийтийн зүгээс шүүмжлэлтэй хандаж байна.⁴ Энэ нь төрийн оролцоо өндөр, удирдлага, зохион байгуулалт, хөрш орнуудын хамтын ажиллагаа, манай улсын экспортын бараа бүтээгдэхүүн зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалах боловч хууль, эрх зүйн орчны ойлгомжтой байдал хийгээд хөрөнгө оруулагчдын эрх ашиг, хөрөнгө оруулалтын баталгааг бүрэн хангаж чадсан эсэхээс мөн хамаарч байна.

Үүнээс үзвэл чөлөөт бүсийг ямар зорилгоор байгуулах, мөн чөлөөт бүсийн төрөл, хэлбэр ямар байх, мөн чөлөөт бүсийн удирдлага, зохион байгуулалт, газар олголт, газрын эрх зүйн харилцаа, эрх зүйн тусгай дэглэмийг тодорхойлох зэрэг асуудал нь хууль тогтоомжийн хувьд тодорхойгүй зохицуулагдсан гэж болно.

Олон улсад парламент нь чөлөөт бүсийн эрх зүйн суурийг бүрдүүлж, харин Засгийн газар нь бодит бүсийг байгуулж хэрэгжүүлж байна. Чөлөөт бүсийг Засгийн газрын шийдвэрээр байгуулах нь бодлогыг шуурхай хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлдэг, өөрөөр хэлбэл Засгийн газар нь эдийн засгийн хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын стратегитай уялдуулан чөлөөт бүсийг байгуулах шийдвэрийг хурдан гаргах боломжтой тул эдийн засгийн өөрчлөлтөд уян хатан хариу үйлдэл үзүүлэх нөхцөлийг бий болгодог байна. Мөн Засгийн газар нь бүсийн дэд бүтэц, санхүүжилт, удирдлагын байгууллагыг байгуулах, төрийн байгууллагуудын уялдаа холбоог хангах үүргийг

³ UNCTAD. (2019). World Investment Report: Special Economic Zones.

⁴З.Мөнгөлжин, Э.Анударь, Эдийн засгийн чөлөөт бүс (Харьцуулсан судалгаа), Хууль дээдлэх ёс сэтгүүл, № 83, цуврал 3, УБ, 2021 он, 166 дахь тал.

хэрэгжүүлдэг тул дэд бүтэц болон хөрөнгө оруулалтын зохион байгуулалтыг төвлөрсөн байдлаар шийдвэрлэх давуу талтай байдаг гэж үздэг.

Чөлөөт бүсийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “чөлөөт бүсийн байршил, чөлөөт бүсэд олгох газар нутгийн хэмжээ, хилийн цэсийг тогтоох, өөрчлөх асуудлыг ..., Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ” хэмээн тусгажээ. Гэхдээ энэ нь чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах ААН, хөрөнгө оруулагч нарт газар ашиглах, түрээслэх баталгааг бүрэн хангаж чадахгүй байна.

Чөлөөт бүсийн удирдлага болон оролцогчийн эрх, үүрэг

Чөлөөт бүсийн тухай хуулийн 8.2-т заасны дагуу чөлөөт бүсийн захирагчийг томилж, чөлөөлөх, чөлөөт бүсийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоог чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах бөгөөд захирагч нь чөлөөт бүсийн өдөр тутмын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, дүрэмд заасан эрх хэмжээний хүрээнд удирдан зохион байгуулдаг.

Хуульд зааснаар чөлөөт бүсийн захиргаа нь хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, дэд бүтэц, газрын харилцааг хөгжүүлэх, хууль эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтэд хяналт тавих, дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, чөлөөт бүсийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах, эдийн засгийн таатай орчныг бүрдүүлэх чиглэлээр Засгийн газрын бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах чиг үүрэг бүхий төрийн захиргааны хуулийн этгээд байна. Мөн чөлөөт бүсийн захиргаа нь улсын төсвөөс санхүүжих бөгөөд чиг үүргээ батлагдсан төсөв, орон тооны хязгаарт багтаан хэрэгжүүлж байна.

Энэхүү зохицуулалт нь шийдвэр гаргах шат дамжлага олон, хэрэгжилтийн байгууллагуудын чиг үүрэг тодорхой бус, түүнчлэн бүсийн захиргааны байгууллагын бие даасан байдал, шийдвэр гаргах эрх хэмжээ харьцангуй хязгаарлагдмал, төрөөс хамаарал бүхий байгаа нь хөрөнгө оруулалт татах, үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, бизнес эрхлэгчдэд таатай орчин бүрдүүлэх, чөлөөт бүсэд зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааг нэг цонхны үйлчилгээгээр хэрэгжүүлэх боломжгүй нөхцөлд хүргэж байна.

Нэг цонхны үйлчилгээ

Чөлөөт бүсийн тухай хуульд чөлөөт бүс дэх төрийн үйлчилгээ нь худалдаа, татвар, бизнесийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх цахим нэг цонхны үйлчилгээнд суурилах талаар тусгасан байдаг хэдий ч ямар үйлчилгээг хамруулах, хэрхэн, хэн хариуцаж ажиллах чиг үүргийг нарийвчлан зохицуулаагүй байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт “Эрх бүхий этгээд уялдаа холбоо бүхий зарим төрлийн зөвшөөрлийн олгох, сунгах үйл ажиллагааг нэг цэгийн үйлчилгээний хэлбэрээр зохион байгуулж болно” гэж, Чөлөөт бүсийн тухай хуулийн 9.2-т “Төрийн үйлчилгээ худалдаа, татварын харилцаа, бизнес, хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх цахим нэг цонхны үйлчилгээнд суурилна” гэж заасан ч өнөөдрийг хүртэл энэ заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Монгол Улсад төрөөс зөвшөөрөлтэй эрхлүүлэх үйл ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулж байгаа бөгөөд уг хуульд 13 чиглэлээр 253 тусгай зөвшөөрлийг давхардсан тоогоор 87 эрх бүхий этгээд, 12 чиглэлээр 123 энгийн зөвшөөрлийг давхардсан тоогоор 34 эрх бүхий этгээд зөвшөөрөл олгохоор тусжээ. Өнөөдрийн байдлаар дээрх зөвшөөрлүүдийг олгох, сунгах, татгалзах, түдгэлзүүлэх, хүчингүйд тооцох харилцааг салбарын 160 гаруй хуулиар нарийвчилан зохицуулж байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.21-д заасан “газар эзэмших, ашиглах”, 12.13-т заасан “согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч, 8.2 дугаар зүйлийн 1.9-д заасан “газар эзэмших, ашиглах”, 11.6-д заасан “тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх” энгийн зөвшөөрлийг чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч олгохоор хуульчилжээ.

Холбогдох хуулиар чөлөөт бүсүүдэд “нэг цонхны үйлчилгээ” нэвтрүүлэх зорилт дэвшүүлсэн боловч бодит хэрэгжилт нь хязгаарлагдмал байгаа нь хэрэгжилтийн судалгаанд дурдагдсан байна. Тухайлбал, эдэлбэр газар дээр баригдах барилга байгууламж барих, төлөвлөлт хийх, чөлөөт бүсийн цэвэр усны шугам сүлжээ, барилга байгууламж барих, чөлөөт бүсэд барилга байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжүүлэх, авто зам, замын байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах зэрэг чөлөөт бүсэд явагдах бүхий л ажиллагааг тухайн орон нутгаас хамааралтай, орон нутгийн ИТХ болон төрийн байгууллагаас зөвшөөрөл олгож байна. Мөн чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу тухайн онд олгох газар ашиглах эрхийг нээлттэй сонгон шалгаруулалтаар олгодог бөгөөд энэхүү ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны газар хариуцан гүйцэтгэдэг байна.

Хууль, журмаар зөвшөөрлийн харилцааг тус тусдаа зохицуулсан, үйл явц нь салангид хэвээр байгаа нь чөлөөт бүсэд хөрөнгө оруулах, бизнес эрхлэх боломжийг хязгаарлаж, хүндрэл учруулж байна.

Мэдээллийн нэгдсэн сан

Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд, хөрөнгө оруулалт, гааль, татвар, зөвшөөрөл, гэрээ, маргаан зэрэг асуудлын мэдээллийг төвлөрүүлсэн, төрийн байгууллагууд хоорондын уялдаа холбоог хангасан мэдээллийн нэгдсэн системийн эрх зүйн үндэс одоогоор тодорхойгүй байна.

Одоогоор чөлөөт бүсэд нэвтрэх систем, чөлөөт бүс дэх аж ахуйн нэгж байгууллагын бүртгэл, мэдээллийг цахимжуулах ажил хийгдэж байгаа бөгөөд чөлөөт бүс тус бүрийн мэдээллийн бааз үүсгэж байгаа мэдээлэл өөр өөр, нэгдсэн стандарт зохицуулалтгүй, хэрэгжилт хангалтгүй байна.

Чөлөөт бүс дэх маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа

Чөлөөт бүс нь гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах стратегийн чухал хэрэгсэл боловч түүний үр ашиг нь зөвхөн татварын хөнгөлөлтөөс бус, эрх зүйн баталгаатай орчин, ялангуяа маргаан шийдвэрлэх найдвартай тогтолцооноос ихээхэн хамаардаг.

Монгол Улсад чөлөөт бүсийн шүүхийн маргааныг шийдвэрлэх тогтолцоо нь ерөнхий шүүхийн системд тулгуурласан бөгөөд иргэний, захиргааны болон арбитрын механизмыг хослуулан ашиглаж байна. Гэсэн хэдий ч чөлөөт бүсэд тусгай шүүхийн тогтолцоо, бүтэц байхгүй, хэрэг хянан шийдвэрлэх харьяалал тодорхой бус байгаа нь чөлөөт бүс хөгжихгүй байгаа томоохон хүчин зүйлийн нэг болж байна.

Чөлөөт бүс дэх шүүхийн асуудал нь эдийн засгийн бодлого болон эрх зүйн тогтолцооны огтлолцолд оршдог нарийн төвөгтэй асуудал юм. Үндэсний шүүхийн харьяалал, олон улсын арбитрын хэрэглээ, эрх зүйн зохицуулалтын уялдаа зэрэг нь чөлөөт бүсийн амжилттай үйл ажиллагаанд шууд нөлөөлдөг.

Судалгаанаас чөлөөт бүс дэх маргааныг ангилаж үзвэл иргэний эрх зүйн маргаан /гэрээний, хөрөнгө оруулалтын, хохирол нөхөн төлүүлэх гэх мэт/, захиргааны маргаан /чөлөөт бүсийн захиргааны байгууллагын шийдвэр, тусгай, энгийн зөвшөөрөл, бүртгэл, татварын маргаан гэх мэт/, олон улсын шинжтэй маргаан /гадаадын хөрөнгө оруулагч оролцсон маргаан, олон улсын гэрээний маргаан гэх мэт/ байна.

Хөрөнгө оруулагчид аливаа улсад хөрөнгө оруулахдаа хамгийн түрүүнд анхаардаг хүчин зүйлсийн нэг нь маргаан үүссэн тохиолдолд түүнийг шударга, хараат бус, хурдан шийдвэрлэх боломж, хууль эрх зүйн зохицуулалт юм.

Монгол Улсад хөрөнгө оруулагчийн эрхийг Хөрөнгө оруулалтын тухай, Арбитрын тухай хуулиар зохицуулж байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Чөлөөт бүсийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланд үндэслэн Эдийн засгийн тусгай бүсийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдуулан боловсруулах хуулийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу боловсруулж дараах харилцааг тусгана:

-Эдийн засгийн тусгай бүсийн тухай хуулийн зорилго, зорилт, үйлчлэх хүрээг тодорхойлж, эдийн засгийн тусгай бүсийн хэлбэрт шилжүүлэх;

-Эдийн засгийн тусгай бүсийг зорилго, үйл ажиллагааны чиглэлээс нь хамааран чөлөөт худалдааны бүс, экспорт боловсруулах бүс, аж үйлдвэрийн парк, шинжлэх ухаан технологийн парк, нэгдсэн тусгай бүс зэргээр төрөлжүүлэх, нэр томьёог тодорхойлох;

-Эдийн засгийн бодлогын хэрэгжилтийг шуурхай, уян хатан байдлаар хангах үүднээс чөлөөт бүс байгуулах өөрчлөх, татан буулгах, түүний хилийн цэс, байршлыг тогтоох эрхийг Монгол Улсын Засгийн газарт өгөх;

-Эдийн засгийн тусгай бүсийн удирдлагын тогтолцоо төвлөрсөн, бие даасан удирдлагатай байх, чөлөөт бүс дэх үйл ажиллагаанд уян хатан, шийдвэр гаргах эрх хэмжээг зохицуулах;

-Эдийн засгийн тусгай бүс дэх төрийн үйлчилгээг “нэг цонхны үйлчилгээ”-ний зарчимд тулгуурлаж, эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх;

-Эрсдэлд суурилсан хяналтын системд зөвшөөрөл болон холбогдох мэдээллийг шилжүүлэн цахимжуулах;

-Эдийн засгийн тусгай бүсийн нутаг дэвсгэрт хэрэгжих тусгай дэглэмээр зохицуулж буй ажиллагаатай холбоотой мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх;

-Эдийн засгийн тусгай бүс дэх маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны шүүхийн тогтолцоог сайжруулах.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Эдийн засгийн тусгай бүсийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар дараах үр дагавр бий болно:

Монгол Улсад хэрэгжиж буй чөлөөт бүсийн эрх зүйн зохицуулалтыг эдийн засгийн тусгай бүсийн (ЭЗТБ) хэлбэрт шилжүүлэх нь бүсийн хөгжлийн бодлогыг илүү өргөн хүрээнд хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой бөгөөд чөлөөт бүс нь ихэвчлэн худалдаа, логистик, татварын хөнгөлөлтөд төвлөрсөн үйл ажиллагаатай байдаг бол эдийн засгийн тусгай бүсийн ойлголт нь үйлдвэрлэл, технологи, инновац, үйлчилгээ, логистик зэрэг олон салбарыг хамарсан хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэх боломжийг олгодог. Иймд хуулийг эдийн засгийн тусгай бүсийн зохицуулалтаар өөрчлөх нь бүсийн үйл ажиллагааны хүрээг өргөжүүлж, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, аж үйлдвэржилтийг дэмжих, бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг хурдасгах бодлогын шинэ механизм бий болно.

Мөн Монгол Улсын Үндсэн хуульд хууль тогтоомж нь хоорондоо уялдаа холбоотой, зөрчилгүй байх зарчмыг тодорхойлсон бөгөөд энэ хүрээнд эдийн засгийн тусгай бүсийн зохицуулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд боловсруулж, чөлөөт бүсийн ойлголтыг нэгтгэн зохицуулах нь хуулийн уялдаа холбоог хангах, эрх зүйн тогтолцооны тогтвортой байдлыг бэхжүүлэх ач холбогдолтой.

Иймд чөлөөт бүсийн талаарх зохицуулалтыг эдийн засгийн тусгай бүсийн өргөн хүрээтэй ойлголтод нэгтгэж, холбогдох бусад хууль тогтоомжтой нийцүүлэх нь эрх зүйн орчныг илүү тодорхой болгох, бодлогын хэрэгжилтийг үр ашигтай болгох, бүсийн хөгжлийг дэмжих, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг тогтвортой болгох, төрийн бодлогын хэрэгжилтийг нэгдсэн байдлаар хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Нөгөө талаас, эдийн засгийн тусгай бүсийн эрх зүйн зохицуулалтыг нэвтрүүлэх нь Монгол Улсыг бүс нутгийн болон олон улсын нийлүүлэлтийн сүлжээнд илүү үр дүнтэй холбох боломжийг бүрдүүлнэ. Энэ нь экспортын чиг баримжаатай үйлдвэрлэлийг хөгжүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зэрэг эдийн засгийн бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй. Түүнчлэн ЭЗТБ-ийн загвар нь олон улсын практикт

өргөн хэрэглэгддэг тул Монгол Улсын бүсийн бодлогыг дэлхийн жишигт нийцүүлэх, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах давуу талтай юм.

Монгол Улс эдийн засгийн тусгай бүсийг олон улсын жишгийн дагуу төрөлжүүлснээр бүс нутгийн онцлогт тохирсон хөгжлийг дэмжих боломжийг бүрдүүлнэ. Төрөлжсөн бүсийн тогтолцоо нь тухайн бүс нутгийн байршил, нөөц боломжид тулгуурлан хөгжих нөхцөлийг бүрдүүлдэг. Жишээлбэл, хил орчмын бүсэд чөлөөт худалдааны бүс, аж үйлдвэр хөгжих боломжтой бүсэд аж үйлдвэрийн парк байгуулах зэрэг бодлого хэрэгжүүлэх боломжтой. Мөн гадаад болон дотоодын хөрөнгө оруулалтыг татахад дэмжлэг болдог. Төрөл бүрийн эдийн засгийн тусгай бүсүүд нь хөрөнгө оруулагчдад тодорхой салбарын чиглэл, татварын болон гаалийн хөнгөлөлттэй нөхцөлийг санал болгодог тул хөрөнгө оруулалтын орчныг илүү ойлгомжтой болно. Мөн Монголын эдийн засаг уул уурхайн салбарт ихээхэн хамааралтай байдаг тул аж үйлдвэр, логистик, технологийн чиглэлийн тусгай бүсүүдийг хөгжүүлэх нь эдийн засгийн бүтцийг олон салбарт тулгуурласан болгоход хувь нэмэр оруулахаас гадна экспортын үйлдвэрлэл болон бүс нутгийн хамтын ажиллагааг нэмэгдүүлж, төрөлжсөн тусгай бүсүүд нь экспортод чиглэсэн үйлдвэрлэл, хил дамнасан худалдааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

Төрийн оролцоог багасгах, үр ашигтай байдал, бүтээмжийг нэмэгдүүлэх, санхүүгийн бие даасан хараат бус байдлыг бүрдүүлэх зорилгоор олон улсын жишиг зохицуулалтын хүрээнд чөлөөт бүсийн удирдлагын тогтолцоог илүү төвлөрсөн, бие даасан удирдлагатай, чөлөөт бүс дэх үйл ажиллагааны аливаа асуудалд уян хатан, шийдвэр гаргах эрх хэмжээтэй байх чиглэлээр боловсронгуй болгох нь улсын хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын стратеги болон бүс нутгийн хөгжлийн төлөвлөлттэй уялдуулан чөлөөт бүсийн байршил, дэд бүтцийн хөгжлийг илүү шуурхай зохион байгуулах, эдийн засаг, хөрөнгө оруулалтын орчин сайжрах ач холбогдолтой.

Эдийн засгийн тусгай бүс нь эдийн засгийг дэмжих, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, худалдаа, үйлдвэрлэлийг хөгжүүлэх чухал хэрэгсэл болдог бөгөөд төрийн үйлчилгээг хурдан шуурхай үзүүлэх, шийдвэр гаргах онцгой бүс байдгаараа онцлогтой юм. Иймд чөлөөт бүс дэх төрийн үйлчилгээг “нэг цонхны үйлчилгээ”-ний зарчимд тулгуурлан зохион байгуулах эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх нь бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, тусгай бүсийг хөгжүүлэх боломж бүрдэнэ.

Мөн төрөөс олгох зөвшөөрлийг эрсдэлд суурилсан хяналтын системд шилжүүлэн зөвшөөрлийн бүхий л процессыг цахимжуулснаар төрийн хүнд суртал буурах, төрийн байгууллагуудын уялдаа холбоо хангагдах, мэдээлэл ил тод, ойлгомжтой, үйл ажиллагаа хурдан шуурхай болох, албан тушаал, авлигын эрсдэл буурах зэрэг талтай.

Эдийн засгийн тусгай бүс дэх маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгохын тулд шүүхийн зохицуулалтыг үндэсний болон олон улсын жишигт нийцсэн байдлаар хуульчлах шаардлагатай байгаа бөгөөд шүүхийн тогтолцоог оновчтой зохион байгуулах, маргаан шийдвэрлэх олон талт механизм нэвтрүүлэх, эрх зүйн тодорхой байдлыг хангах нь чөлөөт бүсийн хөгжлийн үндсэн нөхцөл болно.

Чөлөөт бүс дэх арбитрын шүүх нь зөвхөн маргаан шийдвэрлэх хэрэгсэл биш, харин хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах гол баталгаа юм. Монгол Улсад арбитрын эрх зүйн үндэс бүрдсэн боловч түүнийг чөлөөт бүсийн орчинд илүү идэвхтэй, бодитой хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Иймд арбитрыг чөлөөт бүсийн маргааны үндсэн механизм болгон хөгжүүлэх нь Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах стратегийн чухал алхам болно.

Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд, хөрөнгө оруулалт, гааль, татвар, зөвшөөрөл, маргаан зэрэг асуудлын мэдээллийг төвлөрүүлж, нэгдсэн сангийн тогтолцоог бүрдүүлэх, хариуцах, хяналт тавих этгээдийг тодорхойлох, мэдээллийн нэгдсэн санд төвлөрүүлэх мэдээллийн жагсаалтыг хуульчилснаар чөлөөт бүсийн бодлогыг амжилттай хэрэгжүүлэх суурь нөхцөл бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,

---oOo---

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Эдийн засгийн тусгай бүсийн
тухай /Шинэчилсэн найруулга/
хуулийн төслийн товч танилцуулга

Монгол Улсын Их Хурал “Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай” үзэл баримтлалыг 1995 онд баталж чөлөөт бүс байгуулах үндэслэл, шаардлага, онцлог зарчим, угтвар нөхцөл, баримтлах шалгуур үзүүлэлтийг тодорхойлон өдгөө хүртэл гурван чөлөөт бүс байгуулахаар хууль батлан тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтыг хийсэн боловч бодит байдал дээр чөлөөт бүсээ жинхэнэ утгаар байгуулж чадаагүй байна.

Гадаадын ихэнх улс чөлөөт бүсийг газар зүйн хувьд оновчтой байршилд байгуулан гадаад худалдааны эргэлтийг сайжруулах, экспортыг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар тухайн улс эдийн засгийн олон талын үр ашгийг хүртдэг бөгөөд чөлөөт бүсийг амжилттай хөгжүүлж чадсан улсуудын ихэнх нь далайн боомт болон бусад улстай хил залгаа эдийн засгийн ач холбогдолтой цэгийг сонгон байгуулдаг байна.

Монгол Улсын газар зүйн байрлалын хувьд хоёр улстай хиллэдэг, далайд гарцгүй зэрэг онцлогоо харгалзан Оросын Холбооны улстай хиллэдэг, Алтанбулаг болон Цагааннуур боомт, Бүгд Найрамдах Хятад Ард улстай хиллэдэг, Замын-Үүд боомтод тулгуурлан чөлөөт бүс байгуулсан. Чөлөөт бүсийн үйл ажиллагаа амжилттай явагдахад төрийн бодлого, орон нутгийн оролцоо, бизнес эрхлэгч буюу хөрөнгө оруулагчийн дэмжлэг маш чухал тулгуур хүчин зүйл болдог бөгөөд Монгол Улсын хувьд өнөөг хүртэл хөгжүүлэхээр зорьсон 20 гаруй жилийн туршид ахиц гараагүй шалтгаан нь зөвхөн эрх зүйн орчин бус түүнийг тууштай хэрэгжүүлэх бодлого, дэд бүтцийн бүтээн байгуулалтууд, бизнесийн үйл ажиллагааны уян хатан бодлого, түүнчлэн Засгийн газрын тууштай дэмжлэгийн цогц арга хэмжээг бүхэлдээ хэрэгжүүлж чадаагүй байна.

Тиймээс энэхүү асуудлыг олон талаас нь судалж, хөрөнгө оруулалтыг татах, үндэсний үйлдвэрүүддээ бизнесийн таатай орчныг бий болгох, тээвэр логистикийн сүлжээг бүрдүүлэх, технологийн дэвшлийг дэмжих замаар экспортын хэмжээ, төрлөө нэмэгдүүлэн эдийн засгийн эргэлтээ сайжруулан хөгжлөө хурдасгах оновчтой гарц, шийдлийг санал болгох, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчныг илүү боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Монгол Улсын Их Хурал 2015 оны 02 дугаар сарын 12-ны өдөр Чөлөөт бүсийн тухай хуулийг шинэчлэн баталснаар чөлөөт бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах, түүний байршил, удирдлагын эрх хэмжээ, хяналтын тогтолцоо, чөлөөт бүсэд мөрдөх татвар, гааль, шалган нэвтрүүлэх, хуулийн этгээдийн болон иргэний бүртгэл, хөдөлмөр эрхлэлтийн тусгай дэглэмийн эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн үндэс бүрэлдсэн. Мөн чөлөөт бүсийн тухай хуулиас гадна Гаалийн тухай хууль, гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай Киотогийн конвенцийн зарим холбогдох заалт, Гааль, татварын ерөнхий газрын даргын 2016 оны А/43 дугаар тушаалаар батлагдсан “Чөлөөт бүсийн горимыг хэрэгжүүлэх журам” зэрэг хэм хэмжээгээр чөлөөт бүстэй холбогдох харилцааг зохицуулж байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”¹ -д эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилтын дор эдийн засгийн тэргүүлэх 16 чиглэлийг тодорхойлсонд “Эдийн засгийг тэтгэсэн, уян хатан, цахим технологид суурилсан олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлнэ” гэж “чөлөөт бүс, хилийн боомтуудын барилга байгууламж, тоног төхөөрөмжид шинэчлэлт хийж, олон улсын стандартад нийцүүлэн, нэвтрэх чадварыг нэмэгдүүлнэ” гэж багтаасан.

Монгол Улсын Их Хурал 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”², “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрт тулгуурлан зургаан багц асуудлын хүрээнд хэрэгжүүлэх зорилго, зорилт дэвшүүлсний Эдийн засгийн бодлогын хүрээнд “Чөлөөт бүсүүдийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, экспорт болон дотоодын зах зээлд чиглэсэн худалдаа, үйлчилгээ, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжиж ажиллана” гэж зорилтоо тодорхойлсон байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 91 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэл”³ -д Монгол Улсын Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороодод уул уурхайн бус экспортыг дэмжих бодлогыг нэгтгэн тодорхойлж, санхүүгийн дэд бүтэц, санхүүжилтийн хүртээмжтэй тогтолцоог бүрдүүлэх, бизнесийн орчныг сайжруулах чиглэлээр олон улсын санхүүгийн байгууллага, хувийн хэвшилтэй хамтран ажиллах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгажээ.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”⁴-д Монгол Улсын эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, Коронавируст халдвар /КОВИД-19/-т цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэж, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засаг, дэд бүтэц болон төрийн бүтээмжийг сайжруулахад чиглэсэн 10 хүртэлх жилийн хугацаанд хэрэгжих дунд хугацааны зорилтуудыг тодорхойлсны дотор “Боомтын сэргэлт” багц асуудлын хүрээнд “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан эдийн засгийн чөлөөт бүс, хуурай боомтуудыг үе шаттайгаар байгуулах замаар худалдааны эргэлтийг нэмэгдүүлнэ” гэж заасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.2.2.1-т “Аялал жуулчлал, тээвэр, логистик, олон улсын санхүүгийн төв, эдийн засгийн чөлөөт бүс бүхий эко-ухаалаг Хүннү дагуул хотын бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг үе шаттайгаар шийдвэрлэж, дулааны станц, цэвэрлэх байгууламжийн дэд бүтцийг барьж байгуулна” гэж, 1.2.2.5-д “Хүннү хот дахь чөлөөт бүсийг тулгуурлан

¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2020 он, №36

² Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2020 он, №38

³ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2021, №46

⁴ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2022 он, №09

“Цахиурын хөндий” дата төв хүлэмжийн болон сэргээгдэх эрчим хүчний хосолсон загвар аж ахуйг хөгжүүлнэ” гэж, 1.3.5.4-т “Хөшигийн хөндий болон Алтанбулаг чөлөөт бүсэд ачаа тээвэр, барилгын материалын логистикийн төв байгуулна” гэж, 1.4.1.6-д “Орон нутагт чөлөөт бүс, тусгай бүс, аж үйлдвэрийн парк байгуулж боомт, хөрш орны хотуудтай холбоно” гэж, 3.2.2.11-т “Бүсүүдийн тэргүүлэх чиглэл, онцлог, нөөц, байршлын давуу талд тулгуурлан эдийн засгийн тусгай бүсийг байгуулж, одоо байгаа татварын хөнгөлөлт бүхий чөлөөт бүсүүдийн бүрэн ашиглалтад оруулна” гэж, 3.2.2.12-т “Чөлөөт бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн болон нарийвчилсан төлөвлөгөөнүүдэд тодотгол хийж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, чөлөөт бүсийн хууль, эрх зүйн орчныг шинэчилнэ” гэж, 3.3.5.5-д “Түүх, соёл, байгалийн үзэсгэлэнт газрын нөөц, археологи, палеонтологийн нөөцөд тулгуурласан аялал жуулчлалын чөлөөт бүс байгуулж, жуулчдын нэвтрэх урсгалыг нэмэгдүүлнэ” гэж, 3.3.7.4-т “Мэдээллийн технологи, судалгаа хөгжүүлэлт, инновацын үйл ажиллагаа эрхлэх татварын хөнгөлөлттэй чөлөөт бүс, шинжлэх ухааны паркийг хөгжүүлнэ” гэж, 4.4.2.14-т “Чөлөөт бүсүүдэд бизнес инкубатор төвийг байгуулж, гадаад худалдааны түүхий эд, технологийн солилцоогоор аж ахуй эрхлэгчдийг дэмжинэ” гэсэн зорилтыг дэвшүүлсэн.

Ийнхүү Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг Улсын Их Хурал, Засгийн газраас бодлогын баримт бичгүүдэд зааснаар чөлөөт бүсийн үйл ажиллагааг дэмжих, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хүчин төгөлдөр эрх зүйн орчин бүрдсэн байна.

Чөлөөт бүсийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал

Чөлөөт бүсийг улсууд хөгжлийн түвшингээсээ хамаарч өөр өөр зорилгоор байгуулдаг бөгөөд хөгжингүй улсууд гадаад эдийн засгийн харилцаагаа идэвхжүүлэх, улс хоорондын хөгжлийн ялгааг арилгах бодлого хэрэгжүүлэх, жижиг дунд бизнесийн үйл ажиллагааг сэргээх, худалдааг дэмжих, худалдааны зардлыг бууруулахаар байгуулдаг бол хөгжиж байгаа улсууд дэд бүтцийг бий болгох, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх, орон нутгийн хөгжлийг дэмжих, улсын эдийн засгийг сайжруулах, шинэ техник, технологи нэвтрүүлэх зорилгоор, харин буурай хөгжилтэй улсууд хөрөнгө оруулалтыг татах, техник, технологийн хоцрогдлыг арилгах, ажлын байрыг нэмэгдүүлэхийн тулд чөлөөт бүсийг байгуулдаг.

Худалдааны чөлөөт бүс, экспортыг дэмжих бүс, аж үйлдвэрлэлийн тусгай бүс, далайн тээврийн тусгай боомт, шинжлэх ухаан/технологийн парк, хими технологийн бүс, тээвэр логистикийн төв, санхүүгийн чөлөөт бүс, нисэх буудал тойрсон тээвэр логистик, гаалийн тусгай бүс зэрэг үйл ажиллагааны чиглэлийн хувьд ялгаатай, төрөлжсөн болон нийтлэг үйл ажиллагаа бүхий чөлөөт бүсүүдийг газар нутгийнхаа байрлал, онцлог, дэд бүтцийн нөхцөл байдал, хүрээлэн буй орчин, байгалийн нөөц боломждоо тулгуурлан өөрийн орны эдийн засгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн улс орон бүр өөрийн бодлогоор тодорхойлж байна.

Монгол Улсын Их Хурлын 1995 оны 87-р тогтоолоор “Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал”-ыг анх баталсан. 2002 онд Чөлөөт бүсийн тухай хууль, мөн ондоо “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулийг, 2003 онд “Замын-Үүд” эдийн засгийн болон “Цагааннуур”

худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулиудыг тус тус баталсан юм. Хэдийгээр эрх зүйн орчин бүрдээд бараг 20-иод жилийн хугацаа өнгөрч, үе үеийн Засгийн газруудаас чөлөөт бүсийн үйл ажиллагаа явуулах талаар хүчин чармайлт гаргаж байсан ч чөлөөт бүсүүдийн үйл ажиллагаа хэвийн явагдаж чадаагүй, хүлээсэн үр дүнд хүрээгүй байна.

Иймд 2015 онд улс орны хөгжлийн шаардлага, хэтийн чиг хандлагад нийцүүлэн Чөлөөт бүсийн тухай хуулийг шинэчлэн найруулж баталсан. Энэхүү хуулийг шинэчлэн баталснаар чөлөөт бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах, түүний байршил, удирдлагын эрх хэмжээ, хяналтын тогтолцоо, чөлөөт бүсэд мөрдөх татвар, гааль, шалган нэвтрүүлэх, хуулийн этгээдийн болон иргэний бүртгэл, хөдөлмөр эрхлэлтийн тусгай дэглэмийн эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн үндэс бүрэлдсэн. Хуульд Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд үл харшлах, олон улсын гэрээний тулгуур зарчим, шаардлага болон Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулиар тогтоосон шаардлагад нийцсэн үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал, худалдаа, олон улсын банк, санхүү, төлбөрт таавар, бооцоот тоглоом зэрэг бүх төрлийн үйл ажиллагааг чөлөөт бүсэд явуулж болохоор тусгасан⁵.

Монгол Улсын “Хөрөнгө оруулалтын тухай” хуульд эдийн засгийн тусгай бүсэд хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх тохиолдолд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэхээр тусгагдсан. Татварын энэхүү таатай нөхцөл хөрөнгө оруулагчдыг татах гол хөшүүрэг болох учиртай юм.

Манай улс дотоод зах зээлийн шингээлт багатай, далайд гарцгүй хэдий ч, дэлхийн тэргүүлэх 2 том зах зээл хаяа дэрлэн оршиж байгаа нь туйлын давуу талыг бий болгож байна. Монгол Улсын хувьд олон улсын стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн, үйлчилгээг тэдний эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн хүргэх асуудал болж байна.

Олон улсын туршлагаас үзэхэд чөлөөт бүс байгуулах бодлогыг хэрхэн хэрэгжүүлж байгаагаас түүний үр дүн шууд хамаарч байх бөгөөд тухайн чөлөөт бүсийг стратеги төлөвлөлт, эрэлт хэрэгцээнд суурилсан арга барилаар хангах, дэд бүтцийг шийдвэрлэх, тогтвортой байдлыг хангах, хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх зэргээр төр, засгийн байгууллагуудаас бодитой бөгөөд тууштай дэмжлэг үзүүлж хамтран ажилласнаар амжилттай хэрэгжих үндсэн нөхцөл бүрддэг байна. Чөлөөт бүсийг улсууд олон хэлбэрээр байгуулан ажиллаж байгаа бөгөөд сүүлийн үед аль болох төрийн оролцоог багасгах, үр ашигтай байдал, бүтээмжийг нэмэгдүүлэх, санхүүгийн бие даасан хараат бус байдлыг нь бүрдүүлэх зорилгоор төрийн мэдлээс хувьд шилжүүлэх бодлого баримтлан ажиллаж байна. Чөлөөт бүсийг хамтын ажиллагааны түвшин, өмчийн хэлбэр, зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэлээр нь олон хэлбэрээр ангилан үздэг.

Орчин үед чөлөөт бүсийн төрөл нэмэгдэж аялал жуулчлал, хөдөө аж ахуй, ложистик, мэдээллийн технологийн чиглэлээр бүс байгуулах болсон байна. Монгол Улсад төрөлжсөн чөлөөт бүсийн үйл ажиллагаа чухал байна. Чөлөөт бүсэд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулиар тогтоосон шаардлагад нийцсэн

⁵ Чөлөөт бүсийн тухай хууль (2015) 4.1

үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал, худалдаа, олон улсын банк, санхүү, төлбөрт таавар, бооцоот тоглоом зэрэг бүх төрлийн үйл ажиллагаа явуулж болно.

Монгол Улс нь улс төрийн засаглалын хувьд гадны шууд хөрөнгө оруулалт орж ирэх таатай нөхцөл бүхий ардчилсан тогтолцоотой, Төв Азийн бүс нутагт хараахан бий болоогүй байгаа санхүүгийн чөлөөт бүс байгуулахад байршлын хувьд хамгийн тохиромжтой бөгөөд энэ бүс нутагт санхүүгийн чөлөөт бүсийн орон зай, хэрэгцээ байна.

Байршлын давуу байдлаа ашиглан бүс нутагтаа тээвэр логистик, ачаа тээврийн зангилаа төв болох, эдийн засгаа төрөлжүүлэх, аялал жуулчлалын салбараа тэтгэх хөрөнгө оруулалтын гол хөшүүрэг нь санхүүгийн чөлөөт бүс байгуулж, олон улсын санхүүгийн төв болох зорилтыг богино хугацаанд хэрэгжүүлэхэд төрийн тууштай бодлого, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, нэгдмэл зохион байгуулалттай байх шаардлага бий болж байна.

Манай улсын хувьд нийт 6-н /Улсын Их Хурлын тогтоолоор 4, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор 2/ чөлөөт бүс байгуулсантай холбоотой "Чөлөөт бүсийн тухай" хуулиа "Эдийн засгийн тусгай бүсийн тухай" гэж өөрчилснөөр бүх төрлийн чөлөөт бүсэд үйлчлэх боломжтой эрх зүйн зохицуулалт гэж ойлгож болохоор юм.

Иймд дээр дурдсан нөхцөл байдлын үүднээс Чөлөөт бүсийн тухай хуулийг шинэчилэн боловсруулж Эдийн засгийн тусгай бүсийн тухай /Шинэчилсэн найруулга/-хуулийн төсөлд дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг тусгалаа. Үүнд:

Нэг.Чөлөөт бүсийн тодорхойлолтын талаар:

Чөлөөт бүсийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т “чөлөөт бүс гэж гаалийн татвар болон бусад татварын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна оршиж байгаад тооцогдох, аж ахуйн үйл ажиллагааны тусгай дэглэм бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэсгийг ойлгоно” гэж тодорхойлсон бөгөөд Хүннү хотын эрх зүйн байдлын тухай, Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулиудад “Чөлөөт бүс”, “Эдийн засгийн чөлөөт бүс”, “Эдийн засгийн тусгай бүс”, “Олон улсын санхүүгийн төв” гэх мэт ялгаатай нэршлээр ижил чиг үүрэг бүхий зорилгыг давхардуулан тусгасан нь ойлгомжгүй байдлыг бий болгож, хуулийн хоорондын давхардал, зөрчил үүсгэж байна.

Өөрөөр хэлбэл, Хөшигийн хөндийн чөлөөт бүсэд Хүннү хотын эрх зүйн байдлын тухай хууль давуу үйлчлэх үү, Чөлөөт бүсийн тухай хууль давуу үйлчлэх үү, эсхүл Хүннү хотын эрх зүйн байдлын тухай хууль нь ерөнхий хуулийн байдлаар үйлчилж, Чөлөөт бүсийн тухай хууль нарийвчилсан хууль болж үйлчлэх эсэх зэрэг хууль зүйн хувьд тодорхой болгох, ойлголтыг нэгтгэх шаардлагатай тулгарч байна.

Ийнхүү чөлөөт бүс гэх ойлголтын тодорхойгүй байдалтай холбоотойгоор чөлөөт бүсийн тусгай дэглэмийг тодорхойлох асуудал нь хууль зүйн хувьд тодорхойгүй хэвээр байна. Иймээс чөлөөт бүсийн төрөл, хэлбэр, тусгай дэглэмийн талаар нарийвчлан зохицуулна.

Хоёр.Эдийн засгийн тусгай бүсийн төрөл, хэлбэрийн талаар:

2015 онд баталсан Чөлөөт бүсийн тухай хуулийн зорилт нь “чөлөөт бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах, түүний байршил, удирдлагын эрх хэмжээ, хяналтын тогтолцоо, чөлөөт бүсэд мөрдөх татвар, гааль, шалган нэвтрүүлэх, хуулийн этгээдийн болон иргэний бүртгэл, хөдөлмөр эрхлэлтийн тусгай дэглэмийн эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж, хуулийн зорилго нь “тухайн бүсэд эрх зүй хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлснээр иргэн, аж ахуйн нэгжийн экспорт, импортыг дэмжих, экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, худалдаа, үйлчилгээний шинэ салбар, аялал жуулчлал, хөрөнгө оруулалтыг татах, транзит тээвэр, логистикийг нэмэгдүүлэх, тэргүүний техник, технологийг нутагшуулах, худалдааг хөнгөвчлөх, бүс нутгийн хөгжлийг хурдасгах замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд оршино” гэж тодорхойлсон бөгөөд чөлөөт бүсийн төрөл, хэлбэрийг өөрөөр нарийвчлан хуульчлаагүй байна.

Дэлхийн чөлөөт бүсүүдийн ерөнхий хандлага худалдаанд суурилсан бүсээс илүү техник, технологид түшиглэсэн, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгохыг зорилго болгосон бүсүүдийг хөгжүүлэхэд чиглэж байгаа бөгөөд худалдааны чөлөөт бүс, экспортыг дэмжих бүс, аж үйлдвэрлэлийн тусгай бүс, далайн тээврийн тусгай боомт, шинжлэх ухаан/технологийн парк, хими технологийн бүс, тээвэр ложистикийн төв, санхүүгийн чөлөөт бүс, нисэх буудал тойрсон тээвэр ложистик, гаалийн тусгай бүс зэрэг үйл ажиллагааны чиглэлийн хувьд ялгаатай, төрөлжсөн болон нийтлэг үйл ажиллагаа бүхий чөлөөт бүсүүдийг газар нутгийнхаа байрлал, онцлог, дэд бүтцийн нөхцөл байдал, хүрээлэн буй орчин, байгалийн нөөц боломждоо тулгуурлан өөрийн орны эдийн засгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн улс орон бүр өөрийн бодлогоор тодорхойлж байна.

Олон улсад эдийн засгийн тусгай бүсийг зорилго, үйл ажиллагааны чиглэлээс нь хамааран чөлөөт худалдааны бүс, экспорт боловсруулах бүс, аж үйлдвэрийн парк, шинжлэх ухаан технологийн парк, нэгдсэн тусгай бүс гэсэн үндсэн төрлүүдэд ангилдаг байна.⁶

Энэ хүрээнд чөлөөт бүсүүдийг төрөлжүүлэх асуудлыг төсөлд тусгалаа.

Гурав.Эдийн засгийн тусгай бүсийг байгуулах, өөрчлөх, татан буулгах, түүний хилийн цэс, байршлыг тогтоох талаар:

Чөлөөт бүсийн тухай хуулиар чөлөөт бүс байгуулах өөрчлөх, татан буулгах, түүний хилийн цэс, байршлыг тогтоох, асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал гаргах бүрэн эрхтэй бөгөөд Засгийн газраас санал болгосон хилийн бүсэд чөлөөт бүс байгуулахаар тусгажээ. Түүнчлэн чөлөөт бүсийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах асуудал, бүсийн байршил, хилийн заагийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно гэжээ. Харин хил дамнасан чөлөөт бүсийг Засгийн газар хоорондын хэлэлцээрээр байгуулж, бодлого, үйл ажиллагаагаа эдгээр хэлэлцээрээр зохицуулж болно. Үүнээс үзвэл чөлөөт бүсийг байгуулах, татан буулгах асуудлыг Улсын Их Хурал хэрэгжүүлэхээр зохицуулжээ.

⁶ UNCTAD. (2019). World Investment Report: Special Economic Zones.

Гэвч Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулагдах үйл явц төдийлөн амжилттай хэрэгжиж чадахгүй байгаагийн улмаас олон нийтийн зүгээс шүүмжлэлтэй хандаж байна.⁷ Энэ нь төрийн оролцоо өндөр, удирдлага, зохион байгуулалт, хөрш орнуудын хамтын ажиллагаа, манай улсын экспортын бараа бүтээгдэхүүн зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалах боловч хууль, эрх зүйн орчны ойлгомжтой байдал хийгээд хөрөнгө оруулагчдын эрх ашиг, хөрөнгө оруулалтын баталгааг бүрэн хангаж чадсан эсэхээс мөн хамаарч байна.

Үүнээс үзвэл чөлөөт бүсийг ямар зорилгоор байгуулах, мөн чөлөөт бүсийн төрөл, хэлбэр ямар байх, мөн чөлөөт бүсийн удирдлага, зохион байгуулалт, газар олголт, газрын эрх зүйн харилцаа, эрх зүйн тусгай дэглэмийг тодорхойлох зэрэг асуудал нь хууль тогтоомжийн хувьд тодорхойгүй зохицуулагдсан гэж болно.

Олон улсад парламент нь чөлөөт бүсийн эрх зүйн суурийг бүрдүүлж, харин Засгийн газар нь тодорхой бүсийг байгуулан хэрэгжүүлж байна. Чөлөөт бүсийг Засгийн газрын шийдвэрээр байгуулах нь бодлогыг шуурхай хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлдэг, өөрөөр хэлбэл, Засгийн газар нь эдийн засгийн хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын стратегитай уялдуулан чөлөөт бүсийг байгуулах шийдвэрийг хурдан гаргах боломжтой тул эдийн засгийн өөрчлөлтөд уян хатан хариу үйлдэл үзүүлэх нөхцөлийг бий болгодог байна. Мөн Засгийн газар нь бүсийн дэд бүтэц, санхүүжилт, удирдлагын байгууллагыг байгуулах, төрийн байгууллагуудын уялдаа холбоог хангах үүргийг хэрэгжүүлдэг тул дэд бүтэц болон хөрөнгө оруулалтын зохион байгуулалтыг төвлөрсөн байдлаар шийдвэрлэх давуу талтай байдаг гэж үздэг.

Чөлөөт бүсийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “чөлөөт бүсийн байршил, чөлөөт бүсэд олгох газар нутгийн хэмжээ, хилийн цэсийг тогтоох, өөрчлөх асуудлыг ..., Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ” хэмээн тусгажээ. Гэхдээ энэ нь чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагч нарт газар ашиглах, түрээслэх баталгааг бүрэн хангаж чадахгүй байх тул Монгол Улсын Засгийн газарт эдийн засгийн тусгай бүс байгуулах эрхийг хуулиар өгөх зохицуулалтыг тусгалаа.

Дөрөв.Эдийн засгийн тусгай бүсийн удирдлага болон оролцогчийн эрх, үүргийн талаар:

Чөлөөт бүсийн тухай хуулийн 8.2-т заасны дагуу чөлөөт бүсийн захирагчийг томилж, чөлөөлөх, чөлөөт бүсийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоог чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах бөгөөд захирагч нь чөлөөт бүсийн өдөр тутмын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, дүрэмд заасан эрх хэмжээний хүрээнд удирдан зохион байгуулдаг.

Хуульд зааснаар чөлөөт бүсийн захиргаа нь хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, дэд бүтэц, газрын харилцааг хөгжүүлэх, хууль эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтэд хяналт тавих, дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, чөлөөт бүсийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах, эдийн засгийн таатай орчныг бүрдүүлэх чиглэлээр Засгийн газрын

⁷З.Мөнгөлжин, Э.Анударь, Эдийн засгийн чөлөөт бүс (Харьцуулсан судалгаа), Хууль дээдлэх ёс сэтгүүл, № 83, цуврал 3, УБ, 2021 он, 166 дахь тал.

бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах чиг үүрэг бүхий төрийн захиргааны хуулийн этгээд байна. Мөн чөлөөт бүсийн захиргаа нь улсын төсвөөс санхүүжих бөгөөд чиг үүргээ батлагдсан төсөв, орон тооны хязгаарт багтаан хэрэгжүүлж байна.

Энэхүү зохицуулалт нь шийдвэр гаргах шат дамжлага олон, хэрэгжилтийн байгууллагуудын чиг үүрэг тодорхой бус, түүнчлэн бүсийн захиргааны байгууллагын бие даасан байдал, шийдвэр гаргах эрх хэмжээ харьцангуй хязгаарлагдмал, төрөөс хамаарал бүхий байгаа нь хөрөнгө оруулалт татах, үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, бизнес эрхлэгчдэд таатай орчин бүрдүүлэх, чөлөөт бүсэд зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааг нэг цонхны бодлогыг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдалтай байх тул төр, хувийн хэвшлийн төлөөлөөс бүрдсэн нэгдсэн захиргааг байгуулах асуудлыг тусгалаа.

Тав.Төрийн үйлчилгээг хялбаршуулсан журмаар олгох бодлогын талаар:

Чөлөөт бүсийн тухай хуульд чөлөөт бүс дэх төрийн үйлчилгээ нь худалдаа, татвар, бизнесийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх цахим нэг цонхны үйлчилгээнд суурилах талаар тусгасан байдаг хэдий ч ямар үйлчилгээг хамруулах, хэрхэн, хэн хариуцаж ажиллах чиг үүргийг нарийвчлан зохицуулаагүй байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт “Эрх бүхий этгээд уялдаа холбоо бүхий зарим төрлийн зөвшөөрлийн олгох, сунгах үйл ажиллагааг нэг цэгийн үйлчилгээний хэлбэрээр зохион байгуулж болно” гэж, Чөлөөт бүсийн тухай хуулийн 9.2-т “Төрийн үйлчилгээ худалдаа, татварын харилцаа, бизнес, хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх цахим нэг цонхны үйлчилгээнд суурилна” гэж заасан ч өнөөдрийг хүртэл энэ заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Монгол Улсад төрөөс зөвшөөрөлтэй эрхлүүлэх үйл ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулж байгаа бөгөөд уг хуульд 13 чиглэлээр 253 тусгай зөвшөөрлийг давхардсан тоогоор 87 эрх бүхий этгээд, 12 чиглэлээр 123 энгийн зөвшөөрлийг давхардсан тоогоор 34 эрх бүхий этгээд зөвшөөрөл олгохоор тусжээ. Өнөөдрийн байдлаар дээрх зөвшөөрлүүдийг олгох, сунгах, татгалзах, түдгэлзүүлэх, хүчингүйд тооцох харилцааг салбарын 160 гаруй хуулиар нарийвчлан зохицуулж байна.

Холбогдох хуулиар чөлөөт бүсүүдэд “нэг цонхны үйлчилгээ” нэвтрүүлэх зорилт дэвшүүлсэн боловч бодит хэрэгжилт нь хязгаарлагдмал байгаа нь хэрэгжилтийн судалгаанд дурдагдсан байна. Тухайлбал, эдэлбэр газар дээр баригдах барилга байгууламж барих, төлөвлөлт хийх, чөлөөт бүсийн цэвэр усны шугам сүлжээ, барилга байгууламж барих, чөлөөт бүсэд барилга байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, авто зам, замын байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах зэрэг чөлөөт бүсэд явагдах бүхий л ажиллагааг тухайн орон нутгаас хамааралтай, орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон төрийн байгууллагаас зөвшөөрөл олгож байна.

Мөн чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу тухайн онд олгох газар ашиглах эрхийг нээлттэй сонгон шалгаруулалтаар олгодог бөгөөд энэхүү ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны газар хариуцан гүйцэтгэдэг байна.

Хууль, журмаар зөвшөөрлийн харилцааг тус тусдаа зохицуулсан, үйл явц нь салангид хэвээр байгаа нь чөлөөт бүсэд хөрөнгө оруулах, бизнес эрхлэх боломжийг хязгаарлаж, хүндрэл учруулж байна.

Иймд хуулийн төсөлд чөлөөт бүсэд зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, тухайн чиглэлд хамаарах тусгай, энгийн зөвшөөрлийг цахимаар, богино хугацаанд шийдвэрлэх эрхийг Засгийн газрын холбогдох сайдад хуулиар өгч, шийдвэрлэх журмыг хуулийн төсөлд тусгалаа. Мөн чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн бүртгэл, хөрөнгө оруулалт, гадаадаас ажиллах хүчний мэдээллээс бүрдсэн нэгдсэн санг бүрдүүлэх, сангийн хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг хангах, сангаар дамжуулан төрийн холбогдох байгууллагатай харилцан мэдээлэл солилцох асуудлыг хуульчилж, чөлөөт бүсэд явагдах аливаа үйл ажиллагааг шуурхай, ил тод хангаж, хөрөнгө оруулагчдад таатай бизнесийн таатай орчин бүрдүүлэх асуудлыг төсөлд тусгалаа.

Чөлөөт бүсийн тухай хуулийн өнөөгийн нөхцөл байдал, хэрэгжилттэй холбогдуулан 5 удаагийн уулзалт хэлэлцүүлгийг “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүс, “Замын-Үүд” эдийн засгийн болон “Цагааннуур” худалдааны чөлөөт бүсүүдэд болон Худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран аж ахуйн нэгж байгууллагын төсөөлөл, сэтгүүлч нартай уулзалт, хэлэлцүүлэг хийж, иргэн, аж ахуй нэгж, хөрөнгө оруулагчдаас саналыг нь авсан бөгөөд мөн НҮБ-ын дэргэдэх Дэлхийн чөлөөт бүсийн байгууллага /WFZO/-тай цахим уулзалт хийж, санал солилцох ажлыг хийсэн болно.

---oOo---

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Эдийн засгийн тусгай бүсийн тухай /Шинэчилсэн найруулга/
хуулийн төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтад "... бүс нутгийн хөгжлийн асуудлаар арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх;" гэж, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23.8.16-д "бүсчилсэн хөгжлийн бодлого;" гэж, 27 дугаар зүйлийн 27.5.4-т "Бүсчилсэн хөгжлийн дэд хороо бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс, орон нутгийн хөгжлийн асуудлыг;" гэж, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "... бүс нутгийн харьцангуй жигд хөгжлийг хангах, тэдгээрийн хооронд эдийн засгийн зөв зохистой хэлхээ холбоо тогтоон бэхжүүлэх ..." гэж, 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 2-т "чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт;" гэж заасныг удирдлага болгон Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Зорилт 9.5-д "Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, худалдаа, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд Азийн тээвэр, логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлэх" гэж, Монгол Улсыг 2021-2025 оны хооронд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн 3.1.17-д "Чөлөөт бүсүүдийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, экспорт болон дотоодын зах зээлд чиглэсэн худалдаа, үйлчилгээ, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжиж ажиллана" гэж бодлогын баримт бичигтээ чөлөөт бүсийг хөгжүүлэх гэж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 1.2.2.1-д "Аялал жуулчлал, тээвэр, логистик, олон улсын санхүүгийн төв, эдийн засгийн чөлөөт бүс бүхий эко-ухаалаг Хүннү дагуул хотын бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг үе шаттайгаар шийдвэрлэж, дулааны станц, цэвэрлэх байгууламжийн дэд бүтцийг барьж байгуулна" гэж, 1.2.2.5-д "Хүннү хот дахь чөлөөт бүсийг тулгуурлан "Цахиурын хөндий" дата төв хүлэмжийн болон сэргээгдэх эрчим хүчний хосолсон загвар аж ахуйг хөгжүүлнэ" гэж, 1.3.5.4-т "Хөшигийн хөндий болон Алтанбулаг чөлөөт бүсэд ачаа тээвэр, барилгын материалын логистикийн төв байгуулна" гэж, 1.4.1.6-д "Орон нутагт чөлөөт бүс, тусгай бүс, аж үйлдвэрийн парк байгуулж боомт, хөрш орны хотуудтай холбоно" гэж, 3.2.2.11-д "Бүсүүдийн тэргүүлэх чиглэл, онцлог, нөөц, байршлын давуу талд тулгуурлан эдийн засгийн тусгай бүсийг байгуулж, одоо байгаа татварын хөнгөлөлт бүхий чөлөөт бүсүүдийн бүрэн ашиглалтад оруулна" гэж, 3.2.2.12-д "Чөлөөт бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн болон нарийвчилсан төлөвлөгөөнүүдэд тодотгол хийж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, чөлөөт бүсийн хууль, эрх зүйн орчныг шинэчилнэ" гэж, 3.3.5.5-д "Түүх, соёл, байгалийн үзэсгэлэнт газрын нөөц, археологи, палеонтологийн нөөцөд тулгуурласан аялал жуулчлалын чөлөөт бүс байгуулж, жуулчдын нэвтрэх урсгалыг нэмэгдүүлнэ" гэж, 3.3.7.4-д "Мэдээллийн технологи, судалгаа хөгжүүлэлт, инновацын үйл ажиллагаа эрхлэх татварын хөнгөлөлттэй чөлөөт бүс, шинжлэх ухааны паркийг хөгжүүлнэ" гэж, 4.4.2.14-д "Чөлөөт бүсүүдэд бизнес инкубатор төвийг байгуулж, гадаад худалдааны түүхий эд, технологийн солилцоогоор аж ахуй эрхлэгчдийг дэмжинэ" гэсэн зорилтыг дэвшүүлсэн.

Дэлхийн эдийн засгийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцүүлэн эдийн засгийнхаа эргэлтийг сайжруулан улс орны хөгжлийг хурдасган өсөлтийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Монгол Улсын Их Хурал 2002 оны 38 дугаар тогтоолоор “Алтанбулаг чөлөөт бүс байгуулах тухай”, 2004 оны 17 дугаар тогтоолоор “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс, 2005 оны 74 дүгээр тогтоолоор “Цагаан нуур” худалдааны чөлөөт бүс, 2022 оны 10 дугаар тогтоолоор “Хөшигийн хөндий эдийн засгийн чөлөөт бүс” байгуулахаар шийдвэрлэж, чөлөөт бүсийн газрын талбайн хэмжээ, газрын байршил, хилийн заагийн эргэлтийн цэгийн солбицлыг тогтоожээ.

Манай улсад чөлөөт бүсийн үзэл баримтлал, хууль эрх зүйн орчин бүрэлдээд 10 гаруй жил өнгөрч, энэ хугацаанд улсын төсвөөс нэлээд хөрөнгө оруулсан ч тодорхой үр дүнд хүрч чадахгүй байна.

Монгол Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д эхний ээлжинд ОХУ-тай хил залгаа “Алтанбулаг”, “Цагааннуур”, БНХАУ-тай хил залгаа “Замын-Үүд” боомтод түшиглэн худалдаа, гаалийн тусгай /чөлөөт/ бүсүүд байгуулж, олон улсын жишгийн дагуу уг бүсүүдийн хүрээнд дотоод, гадаадын худалдаа эрхлэгчид, хөрөнгө оруулагчид харилцан ашигтай, хамтран ажиллах бизнесийн орчныг бүрдүүлэх, зохих туршлага бүрдмэгц Монгол Улсын нутаг дэвсгэрийн гүнд тусгай /чөлөөт/ бүсийг зохистой төрөл, чиглэлээр байгуулах ажлыг өргөжүүлэх зорилтын хүрээнд “Алтанбулаг”, “Замын-Үүд”, “Цагааннуур” чөлөөт бүсийг байгуулсан.

Гэвч “Алтанбулаг”, “Замын-Үүд”, “Цагааннуур”-ын чөлөөт бүсүүдийн одоогийн үйл ажиллагаа нь чөлөөт бүсийн хөгжил, түүнийг дагасан хотжилт, бүтээн байгуулалт, үйлдвэржилтийн талаар тодорхой ахиц үгүй, эдийн засагт тус нэмэр болох тухай анхны зорилтууд нь хэрэгжээгүйгээс эдгээр чөлөөт бүсүүд үр ашиггүй гэж нэрлэгдэх болж байна.

Иймд чөлөөт бүс нь улсын төсвөөр тэтгүүлдэг биш өөрөө өөрийгөө санхүүжүүлээд зогсохгүй улсын төсөвт хөрөнгө төвлөрүүлдэг газар болгож өөрчлөх зарчмын үндсэн дээр эрх зүйн орчинг улс орны хөгжлийн өнөөгийн шаардлага, хэтийн чиг хандлага, тэргүүлэх туршлагад нийцүүлэн боловсронгуй болгох шаардлагатай байна.

2024 оны байдлаар дэлхийн 145 улсад 5400 орчим эдийн засгийн тусгай бүс /ЭЗТБ/ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээр нь ойролцоогоор 500-600 тэрбум ам.долларын экспортын бараа бүтээгдэхүүний эргэлт хийж, 100 сая хүнийг ажлын байраар хангаж байна.¹

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу шинэчилсэн найруулга хэлбэрээр боловсруулж, мөн хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгыг танилцуулж байна.

Хуулийн төсөлд дараах өөрчлөлтийг тусгалаа. Үүнд:

Нэг.Эдийн засгийн тусгай бүсийн тодорхойлолтын талаар:

¹ UNCTAD. World Investment Report 2019: Special Economic Zones. United Nations Conference on Trade and Development, Geneva, 2019.

Чөлөөт бүсийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т “чөлөөт бүс гэж гаалийн татвар болон бусад татварын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна оршиж байгаад тооцогдох, аж ахуйн үйл ажиллагааны тусгай дэглэм бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэсгийг ойлгоно” гэж тодорхойлсон бөгөөд Хүннү хотын эрх зүйн байдлын тухай, Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулиудад “Чөлөөт бүс”, “Эдийн засгийн чөлөөт бүс”, “Эдийн засгийн тусгай бүс”, “Олон улсын санхүүгийн төв” гэх мэт ялгаатай нэршлээр ижил чиг үүрэг бүхий зорилгыг давхардуулан тусгасан нь ойлгомжгүй байдлыг бий болгож, хуулийн хоорондын давхардал, зөрчил үүсгэж байна.

Өөрөөр хэлбэл, Хөшигийн хөндийн чөлөөт бүсэд Хүннү хотын эрх зүйн байдлын тухай хууль давуу үйлчлэх үү, Чөлөөт бүсийн тухай хууль давуу үйлчлэх үү, эсхүл Хүннү хотын эрх зүйн байдлын тухай хууль нь ерөнхий хуулийн байдлаар үйлчилж, Чөлөөт бүсийн тухай хууль нарийвчилсан хууль болж үйлчлэх эсэх зэрэг хууль зүйн хувьд тодорхой болгох, ойлголтыг нэгтгэх шаардлагатай тулгарч байна.

Ийнхүү чөлөөт бүс гэх ойлголтын тодорхойгүй байдалтай холбоотойгоор чөлөөт бүсийн тусгай дэглэмийг тодорхойлох асуудал нь хууль зүйн хувьд тодорхойгүй хэвээр байна. Иймээс чөлөөт бүсийн төрөл, хэлбэр, тусгай дэглэмийн талаар нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

Олон улсын эрх зүйн харьцуулалтын хүрээнд авч үзвэл дэлхийн улс орнууд, тухайлбал, Япон, Индонези, Филиппин, Мьянмар, Камбож зэрэг улсууд чөлөөт бүсийн тухай хуулиа “Эдийн засгийн тусгай бүсийн тухай” буюу Special economic zone гэж нэрлэсэн байх ба тусгай бүс нь чөлөөт худалдааны, экспорт боловсруулалтын, эдийн засгийн, аж үйлдвэрийн, эдийн засгийн хамтын ажиллагааны зэрэг чөлөөт бүсийн төрлүүдийг өөртөө багтаасан өргөн хүрээтэй ойлголт байна.

Манай улсын хувьд Улсын Их Хурлын тогтоолоор 4, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2 тогтоолоор чөлөөт бүс байгуулсантай холбоотой “Чөлөөт бүсийн тухай” хуулийг “Эдийн засгийн тусгай бүсийн тухай” гэж өөрчилснөөр бүх төрлийн чөлөөт бүсэд үйлчлэх боломжтой эрх зүйн зохицуулалт гэж ойлгож болохоор юм.

Чөлөөт бүсийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалт, 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэг нь бусад чөлөөт бүс гэх ойлголтоос ялгамжтай байдлаар буюу эдийн засгийн хамтын ажиллагааны бүс гэх нэршилийг тодорхойлсон байгааг, мөн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 39.1-т “Тусгай бүс байгуулах чиглэл” гэж зааснаас үзвэл чөлөөт бүсүүдийн зорилго, төрлийн хувьд өөр өөр болохыг, мөн чөлөөт бүсэд тодорхой нэг нэгдсэн нэршил, зохицуулалт шаардлагатай болохыг харуулж байна.

Дэлхийн олон улсын судалгаанд эдийн засгийн тусгай бүсийг хөгжлийн үе шатны хувьд SEZ 1.0, SEZ 2.0, SEZ 3.0 гэсэн ангиллаар авч үздэг бөгөөд Монгол Улсад хэрэгжиж буй чөлөөт бүсүүд нь үндсэндээ SEZ 1.0 болон SEZ 2.0 үе шатны онцлогтой гэж үзэж болно. Тухайлбал, Алтанбулаг, Замын-Үүд, Цагааннуур зэрэг чөлөөт бүсүүд нь худалдаа, үйлчилгээ, логистик болон экспортын үйл ажиллагааг дэмжих зорилготой байгуулагдсан бөгөөд татвар, гаалийн хөнгөлөлтөөр дамжуулан гадаад худалдааг өргөжүүлэхэд чиглэсэн уламжлалт бүсийн шинжийг агуулж байна. Энэ нь экспортын үйлдвэрлэл, худалдааг дэмжих зорилготой SEZ 1.0 загвартай

нийцэж байгаа бөгөөд цаашид SEZ 3.0 загварт шилжих шаардлагатай байгааг судалгаанд дурдсан байна.

Хоёр.Эдийн засгийн тусгай бүсийн төрөл, хэлбэрийн талаар:

2015 онд баталсан Чөлөөт бүсийн тухай хуулийн зорилт нь “чөлөөт бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах, түүний байршил, удирдлагын эрх хэмжээ, хяналтын тогтолцоо, чөлөөт бүсэд мөрдөх татвар, гааль, шалган нэвтрүүлэх, хуулийн этгээдийн болон иргэний бүртгэл, хөдөлмөр эрхлэлтийн тусгай дэглэмийн эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж, хуулийн зорилго нь “тухайн бүсэд эрх зүй хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлснээр иргэн, аж ахуйн нэгжийн экспорт, импортыг дэмжих, экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, худалдаа, үйлчилгээний шинэ салбар, аялал жуулчлал, хөрөнгө оруулалтыг татах, транзит тээвэр, логистикийг нэмэгдүүлэх, тэргүүний техник, технологийг нутагшуулах, худалдааг хөнгөвчлөх, бүс нутгийн хөгжлийг хурдасгах замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд оршино” гэж тодорхойлсон бөгөөд чөлөөт бүсийн төрөл, хэлбэрийг өөрөөр нарийвчлан хуульчлаагүй байна.

Дэлхийн чөлөөт бүсүүдийн ерөнхий хандлага худалдаанд суурилсан бүсээс илүү техник, технологид түшиглэсэн, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгохыг зорилго болгосон бүсүүдийг хөгжүүлэхэд чиглэж байгаа бөгөөд худалдааны чөлөөт бүс, экспортыг дэмжих бүс, аж үйлдвэрлэлийн тусгай бүс, далайн тээврийн тусгай боомт, шинжлэх ухаан/технологийн парк, хими технологийн бүс, тээвэр ложистикийн төв, санхүүгийн чөлөөт бүс, нисэх буудал тойрсон тээвэр ложистик, гаалийн тусгай бүс зэрэг үйл ажиллагааны чиглэлийн хувьд ялгаатай, төрөлжсөн болон нийтлэг үйл ажиллагаа бүхий чөлөөт бүсүүдийг газар нутгийнхаа байрлал, онцлог, дэд бүтцийн нөхцөл байдал, хүрээлэн буй орчин, байгалийн нөөц боломждоо тулгуурлан өөрийн орны эдийн засгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн улс орон бүр өөрийн бодлогоор тодорхойлж байна.

Олон улсад эдийн засгийн тусгай бүсийг зорилго, үйл ажиллагааны чиглэлээс нь хамааран чөлөөт худалдааны бүс, экспорт боловсруулах бүс, аж үйлдвэрийн парк, шинжлэх ухаан технологийн парк, нэгдсэн тусгай бүс гэсэн үндсэн төрлүүдэд ангилдаг байна.²

Хуулийн төсөлд Эдийн засгийн тусгай бүсийг төрөлжүүлэн худалдааны, аж үйлдвэрийн, инновац, технологийн, боомтын, аялал жуулчлалын, тээвэр, логистикийн, хөдөө аж ахуйн чөлөөт бүстэй байхаар тусгасан.

Гурав.Эдийн засгийн тусгай бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах, түүний хилийн цэс, байршлыг тогтоох талаар:

Чөлөөт бүсийн тухай хуулиар чөлөөт бүс байгуулах өөрчлөх, татан буулгах, түүний хилийн цэс, байршлыг тогтоох, асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал гаргах бүрэн эрхтэй бөгөөд Засгийн газраас санал болгосон хилийн бүсэд чөлөөт бүс байгуулахаар тусгажээ. Түүнчлэн чөлөөт бүсийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах асуудал, бүсийн байршил, хилийн заагийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно гэжээ. Харин хил дамнасан

² UNCTAD. (2019). World Investment Report: Special Economic Zones.

чөлөөт бүсийг Засгийн газар хоорондын хэлэлцээрээр байгуулж, бодлого, үйл ажиллагаагаа эдгээр хэлэлцээрээр зохицуулж болно. Үүнээс үзвэл чөлөөт бүсийг байгуулах, татан буулгах асуудлыг Улсын Их Хурал хэрэгжүүлэхээр зохицуулжээ.

Гэвч Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулагдах үйл явц төдийлөн амжилттай хэрэгжиж чадахгүй байгаагийн улмаас олон нийтийн зүгээс шүүмжлэлтэй хандаж байна.³ Энэ нь төрийн оролцоо өндөр, удирдлага, зохион байгуулалт, хөрш орнуудын хамтын ажиллагаа, манай улсын экспортын бараа бүтээгдэхүүн зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалах боловч хууль, эрх зүйн орчны ойлгомжтой байдал хийгээд хөрөнгө оруулагчдын эрх ашиг, хөрөнгө оруулалтын баталгааг бүрэн хангаж чадсан эсэхээс мөн хамаарч байна.

Үүнээс үзвэл чөлөөт бүсийг ямар зорилгоор байгуулах, мөн чөлөөт бүсийн төрөл, хэлбэр ямар байх, мөн чөлөөт бүсийн удирдлага, зохион байгуулалт, газар олголт, газрын эрх зүйн харилцаа, эрх зүйн тусгай дэглэмийг тодорхойлох зэрэг асуудал нь хууль тогтоомжийн хувьд тодорхойгүй зохицуулагдсан гэж болно.

Олон улсад парламент нь чөлөөт бүсийн эрх зүйн суурийг бүрдүүлж, харин Засгийн газар нь тодорхой бүсийг байгуулан хэрэгжүүлж байна. Чөлөөт бүсийг Засгийн газрын шийдвэрээр байгуулах нь бодлогыг шуурхай хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлдэг, өөрөөр хэлбэл, Засгийн газар нь эдийн засгийн хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын стратегитай уялдуулан чөлөөт бүсийг байгуулах шийдвэрийг хурдан гаргах боломжтой тул эдийн засгийн өөрчлөлтөд уян хатан хариу үйлдэл үзүүлэх нөхцөлийг бий болгодог байна. Мөн Засгийн газар нь бүсийн дэд бүтэц, санхүүжилт, удирдлагын байгууллагыг байгуулах, төрийн байгууллагуудын уялдаа холбоог хангах үүргийг хэрэгжүүлдэг тул дэд бүтэц болон хөрөнгө оруулалтын зохион байгуулалтыг төвлөрсөн байдлаар шийдвэрлэх давуу талтай байдаг гэж үздэг.

Чөлөөт бүсийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “чөлөөт бүсийн байршил, чөлөөт бүсэд олгох газар нутгийн хэмжээ, хилийн цэсийг тогтоох, өөрчлөх асуудлыг ..., Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ” хэмээн тусгажээ. Гэхдээ энэ нь чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагч нарт газар ашиглах, түрээслэх баталгааг бүрэн хангаж чадахгүй байна.

Дөрөв.Чөлөөт бүсийн удирдлага болон оролцогчийн эрх, үүргийн талаар:

Чөлөөт бүсийн тухай хуулийн 8.2-т заасны дагуу чөлөөт бүсийн захирагчийг томилж, чөлөөлөх, чөлөөт бүсийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоог чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах бөгөөд захирагч нь чөлөөт бүсийн өдөр тутмын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, дүрэмд заасан эрх хэмжээний хүрээнд удирдан зохион байгуулдаг.

Хуульд зааснаар чөлөөт бүсийн захиргаа нь хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, дэд бүтэц, газрын харилцааг хөгжүүлэх, хууль эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтэд хяналт тавих, дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, чөлөөт бүсийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах, эдийн засгийн таатай орчныг бүрдүүлэх

³³Мөнгөлжин, Э.Анударь, Эдийн засгийн чөлөөт бүс (Харьцуулсан судалгаа), Хууль дээдлэх ёс сэтгүүл, № 83, цуврал 3, УБ, 2021 он, 166 дахь тал.

чиглэлээр Засгийн газрын бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах чиг үүрэг бүхий төрийн захиргааны хуулийн этгээд байна. Мөн чөлөөт бүсийн захиргаа нь улсын төсвөөс санхүүжих бөгөөд чиг үүргээ батлагдсан төсөв, орон тооны хязгаарт багтаан хэрэгжүүлж байна.

Энэхүү зохицуулалт нь шийдвэр гаргах шат дамжлага олон, хэрэгжилтийн байгууллагуудын чиг үүрэг тодорхой бус, түүнчлэн бүсийн захиргааны байгууллагын бие даасан байдал, шийдвэр гаргах эрх хэмжээ харьцангуй хязгаарлагдмал, төрөөс хамаарал бүхий байгаа нь хөрөнгө оруулалт татах, үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, бизнес эрхлэгчдэд таатай орчин бүрдүүлэх, чөлөөт бүсэд зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааг нэг цонхны бодлогыг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдалтай байна.

Тав.Төрийн үйлчилгээг хялбаршуулсан журмаар явуулах бодлогын талаар:

Чөлөөт бүсийн тухай хуульд чөлөөт бүс дэх төрийн үйлчилгээ нь худалдаа, татвар, бизнесийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх цахим нэг цонхны үйлчилгээнд суурилах талаар тусгасан байдаг хэдий ч ямар үйлчилгээг хамруулах, хэрхэн, хэн хариуцаж ажиллах чиг үүргийг нарийвчлан зохицуулаагүй байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт “Эрх бүхий этгээд уялдаа холбоо бүхий зарим төрлийн зөвшөөрлийн олгох, сунгах үйл ажиллагааг нэг цэгийн үйлчилгээний хэлбэрээр зохион байгуулж болно” гэж, Чөлөөт бүсийн тухай хуулийн 9.2-т “Төрийн үйлчилгээ худалдаа, татварын харилцаа, бизнес, хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх цахим нэг цонхны үйлчилгээнд суурилна” гэж заасан ч өнөөдрийг хүртэл энэ заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Монгол Улсад төрөөс зөвшөөрөлтэй эрхлүүлэх үйл ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулж байгаа бөгөөд уг хуульд 13 чиглэлээр 253 тусгай зөвшөөрлийг давхардсан тоогоор 87 эрх бүхий этгээд, 12 чиглэлээр 123 энгийн зөвшөөрлийг давхардсан тоогоор 34 эрх бүхий этгээд зөвшөөрөл олгохоор тусжээ. Өнөөдрийн байдлаар дээрх зөвшөөрлүүдийг олгох, сунгах, татгалзах, түдгэлзүүлэх, хүчингүйд тооцох харилцааг салбарын 160 гаруй хуулиар нарийвчилан зохицуулж байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.21-д заасан “газар эзэмших, ашиглах”, 12.13-т заасан “согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч, 8.2 дугаар зүйлийн 1.9-д заасан “газар эзэмших, ашиглах”, 11.6-д заасан “тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх” энгийн зөвшөөрлийг чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч олгохоор хуульчилжээ.

Холбогдох хуулиар чөлөөт бүсүүдэд “нэг цонхны үйлчилгээ” нэвтрүүлэх зорилт дэвшүүлсэн боловч бодит хэрэгжилт нь хязгаарлагдмал байгаа нь хэрэгжилтийн судалгаанд дурдагдсан байна. Тухайлбал, эдэлбэр газар дээр баригдах барилга байгууламж барих, төлөвлөлт хийх, чөлөөт бүсийн цэвэр усны шугам сүлжээ, барилга байгууламж барих, чөлөөт бүсэд барилга байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжүүлэх, авто зам, замын байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах зэрэг чөлөөт бүсэд явагдах бүхий л ажиллагааг тухайн орон нутгаас хамааралтай, орон

нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон төрийн байгууллагаас зөвшөөрөл олгож байна.

Мөн чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу тухайн онд олгох газар ашиглах эрхийг нээлттэй сонгон шалгаруулалтаар олгодог бөгөөд энэхүү ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны газар хариуцан гүйцэтгэдэг байна.

Хууль, журмаар зөвшөөрлийн харилцааг тус тусдаа зохицуулсан, үйл явц нь салангид хэвээр байгаа нь чөлөөт бүсэд хөрөнгө оруулах, бизнес эрхлэх боломжийг хязгаарлаж, хүндрэл учруулж байна.

Мөн Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн бүртгэл, хөрөнгө оруулалт, гадаадаас ажиллах хүчний мэдээллийг нэгтгэн мэдээлийн сан бүрдүүлэх, сангийн хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг хангах, сангаар дамжуулан төрийн холбогдох байгууллагатай харилцан мэдээлэл солилцох журмыг батлах шаардлагатай байна.

Чөлөөт бүсийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан болон иргэн, хуулийн этгээд, холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагаас ирүүлсэн саналыг үндэслэн Чөлөөт бүсийн тухай хуулийг шинэчилэн Эдийн засгийн тусгай бүсийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн төсөл болон дагалдуулан боловсруулах хуулийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу боловсруулж дараах харилцааг тусгана. Үүнд:

-Хуулийн нэрийг Эдийн засгийн тусгай бүс /Шинэчилсэн найруулга/-ийн тухай болгож, хуулийн зорилго, зорилт, үйлчлэх хүрээг эдийн засгийн тусгай бүс (ЭЗТБ)-ээр тодорхойлж, чөлөөт бүсийг эдийн засгийн тусгай бүсийн хэлбэрт шилжүүлэх;

-Эдийн засгийн тусгай бүсийг зорилго, үйл ажиллагааны чиглэлээс нь хамааран худалдааны чөлөөт бүс, аж үйлдвэрийн чөлөөт бүс; инноваци, технологийн чөлөөт бүс; аялал жуулчлалын чөлөөт бүс, тээвэр, логистикийн чөлөөт бүс, хөдөө аж ахуйн чөлөөт бүсийг төрөлжүүлэх, нэр томъёог тодорхойлох;

-Эдийн засгийн бодлогын хэрэгжилтийг шуурхай, уян хатан байдлаар хангах үүднээс чөлөөт бүс байгуулах өөрчлөх, татан буулгах, түүний хилийн цэс, байршлыг тогтоох эрхийг Монгол Улсын Засгийн газарт өгөх;

-Эдийн засгийн тусгай бүсийн удирдлагын тогтолцоо төвлөрсөн, бие даасан удирдлагатай байх, тусгай бүс дэх үйл ажиллагаанд уян хатан, шийдвэр гаргах эрх хэмжээг зохицуулах;

-Эдийн засгийн тусгай бүс дэх төрийн үйлчилгээг хялбаршуулсан журмаар хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх;

-Эрсдэлд суурилсан хяналтын системд шилжүүлэн зөвшөөрөл болон холбогдох мэдээллийг цахимжуулах;

-Эдийн засгийн тусгай бүсийн нутаг дэвсгэрт хэрэгжих тусгай дэглэмээр зохицуулж буй ажиллагаатай холбоотой мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх;

-Эдийн засгийн тусгай бүс дэх маргаан хянан шийдвэрлэх бие даасан шүүхийн тогтолцооны зохицуулалт.

Эдийн засгийн тусгай бүсийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн төслөөр чөлөөт бүсийг эдийн засгийн тусгай бүсийн хэлбэрт шилжүүлж, бүсийг төрөлжүүлэн хөгжүүлэх, тусгай бүсийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад төрийн үйлчилгээг нээлттэй, ил тод, хүртээмжтэй хүргэх, эрсдэлд суурилсан хяналтын системд шилжүүлэн зөвшөөрөл болон мэдээллийг цахимжуулах, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлнэ.

Эдийн засгийн тусгай бүсийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улс дэлхийн эдийн засгийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцүүлэн эдийн засгийн чөлөөт бүсийг хөгжүүлэх, эдийн засгийн эргэлтийг сайжруулах, улс орны хөгжлийг хурдасгах, улсын төсөв, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, чөлөөт бүсийн хөгжлийг дагасан хотжилт, бүтээн байгуулалт, дэд бүтэц, үйлдвэржилт, хүн амын төвлөрлийг сааруулахад чухал ач холбогдолтой юм.

Хуулийн төсөлд туссан асуудалтай холбогдуулан 8 хуульд хууль хоорондын нийцэл, уялдааг хангах, хуулийн нэр томъёоны болон зарчмын шинжтэй өөрчлөлтийг тусгах болно.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭДИЙН ЗАСГИЙН ТУСГАЙ БҮСИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь экспортод чиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх замаар бүс нутгийн эдийн засгийн өсөлтийг дэмжих, технологи, ногоон хөгжил, инновацийг нэвтрүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, чөлөөт бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах, нэгтгэх, түүний хилийн цэс, байршлыг тогтоох, удирдлагын тогтолцоо, чиг үүргийг тодорхойлох, чөлөөт бүсэд мөрдөх гааль, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, хуулийн этгээдийн бүртгэл, хөдөлмөр эрхлэлтийн болон холбогдох бусад үйл ажиллагааны тусгай дэглэмийн эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Эдийн засгийн бүсийн тухай хууль тогтоомж

2.1.Эдийн засгийн тусгай бүсийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“эдийн засгийн тусгай бүс” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийг зааглан хязгаарлаж, гааль, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, хөрөнгө оруулалт болон үйл ажиллагааны эрх зүйн онцгой дэглэм тогтоосон нутаг дэвсгэрийг;

3.1.2.“эдийн засгийн тусгай бүс дэх эрх зүйн дэглэм” гэж тусгай бүсийн нутаг дэвсгэрт хэрэгжих энэ хуульд заасан тусгай зохицуулалтыг;

¹ Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

3.1.3.“чөлөөт бүс” гэж гаалийн татвар болон бусад татварын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна оршиж байгаад тооцогдох, аж ахуйн үйл ажиллагааны тусгай дэглэм бүхий эдийн засгийн тусгай бүсийн хэлбэрийг;

3.1.4.“гаалийн нутаг дэвсгэр” гэж Гаалийн тухай хуулийн² 4.1-д заасныг;

3.1.5.“гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт” гэж Гаалийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасныг;

3.1.6.“тарифын бус хязгаарлалт” гэж Гаалийн тухай хуулийн 3.1.14-т заасныг;

3.1.7.“худалдааг хөнгөвчлөх” гэж олон улсын худалдааны үйл явц буюу худалдагчаас худалдан авагчид бараа, түүхий эд, бүтээгдэхүүнийг нийлүүлэх, зураасан кодыг бүртгэх, төлбөр төлөхтэй холбоотой мэдээллийн урсгал, өгөгдөл, баримт бичгийг цөөлөх, хялбаршуулах, харилцан уялдуулах зэрэг үйл ажиллагааг;

3.1.8.“зураасан код” гэж бараа, түүхий эд, бүтээгдэхүүн, үйлчилгээг тодорхойлох давхардахгүй дугаарыг.

3.1.9.“чөлөөт бүсэд зорчих” гэж Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн албан болон хувийн хэргээр чөлөөт бүсэд нэвтрэхийг;

3.1.10.“монголын бараа” гэж Гаалийн тухай хуулийн 3.1.2-т заасныг;

3.1.11.“чөлөөт бүсэд үйлдвэрлэсэн бараа” гэж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулсан нэмэгдсэн өртгийн 40-өөс дээш хувь нь чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт бий болсон барааг;

3.1.12.“эдийн засгийн хамтын ажиллагааны бүс” гэж хил залгаа улстай тус тусын хилийн зурвас дахь газарт Засгийн газар хоорондын хэлэлцээрт үндэслэн байгуулсан чөлөөт бүсийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ЭДИЙН ЗАСГИЙН ТУСГАЙ БҮС

4.1.Эдийн засгийн тусгай бүс нь үйл ажиллагааны чиглэл, зорилгоос хамааран дараах төрөлжсөн чөлөөт бүс /цаашид “чөлөөт бүс” гэх/-тэй байна.

- 4.1.1.Худалдааны чөлөөт бүс;
- 4.1.2.Аж үйлдвэрийн чөлөөт бүс;
- 4.1.3.Инноваци, технологийн чөлөөт бүс;
- 4.1.4.Аялал жуулчлалын чөлөөт бүс;
- 4.1.5.Тээвэр, логистикийн чөлөөт бүс;
- 4.1.6.Хөдөө аж ахуйн чөлөөт бүс.

4.2.Монгол Улсад эдийн засгийн тусгай бүс байгуулах асуудлыг энэ хуулиар зохицуулна.

4.3.Засгийн газар улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан энэ зүйлийн 4.1-д зааснаас өөр төрлөөр чөлөөт бүс байгуулж болно.”

² Гаалийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2008 оны 23 дугаарт нийтлэгдсэн.

5 дугаар зүйл.Эдийн засгийн тусгай бүс байгуулахад баримтлах зарчим, угтвар нөхцөл

5.1.Эдийн засгийн тусгай бүсийг байгуулахад төрөөс дараах зарчмыг баримтална:

5.1.1.хөрөнгө оруулалт, бизнесийг дэмжих зорилгоор нээлттэй, ил тод, шударга өрсөлдөөнд суурилсан байх;

5.1.2.чөлөөт бүс байрлах бүс нутагт авто зам, төмөр зам, нисэх онгоцны буудал зэрэг шаардлагатай дэд бүтэцтэй байх буюу эдгээр дэд бүтцийг хөгжүүлэх боломжтой байх;

5.1.3.чөлөөт бүсэд ашиглах усны нөөц, эрчим хүчний хангамжтай байх;
5.1.4.хот байгуулалтын норм, дүрэм, стандарт, орон зайн нөхцөлийг хангасан байх;

5.1.5.хөрөнгө оруулагч, аж ахуйн нэгж, байгууллагын тогтвортой үйл ажиллагаа эрхлэх таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх;

5.1.6.байгаль орчинд ээлтэй байх;

5.1.7.бүс нутгийн тогтвортой хөгжил, орон нутгийн эдийн засгийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, мэргэжлийн ажилтныг бэлтгэх нарийвчилсан төлөвлөгөөтэй байх.

5.1.8.чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэгчийн өмч, хөрөнгө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

5.1.9.чөлөөт бүсийн байршлыг бүсчилсэн хөгжлийн бодлого, тухайн бүс нутгийн онцлог, газарзүйн байршил, дэд бүтэц, логистик, зах зээл, байгаль орчин, хүн амын нөөцтэй уялдуулан оновчтой тогтоох.

6 дугаар зүйл.Эдийн засгийн тусгай бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах, нэгтгэх, түүний хилийн цэс, байршлыг тогтоох, үйл ажиллагааг нээх, түр хаах

6.1.Эдийн засгийн тусгай бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах, нэгтгэх, чөлөөт бүсийн хилийн цэс, байршлыг тогтоох, өөрчлөх, чөлөөт бүсийн үйл ажиллагааны зорилго, чиглэлийг тогтоох, чөлөөт бүсийн газар нутгийн хэмжээг Засгийн газар шийдвэрлэнэ.

6.2.Аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал тухайн нутаг дэвсгэрийнхээ тодорхой хэсэгт чөлөөт бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах, хилийн цэс, байршлийг тогтоох саналыг Засгийн газарт хүргүүлнэ.

6.3.Эдийн засгийн бүсийг хилийн зурвас дахь газарт болон бүс нутагт байгуулна.

6.4.Эдийн засгийн тусгай бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах, нэгтгэх, бүсийн газар нутгийн хэмжээ, хилийн цэс, байршлыг тогтоох, өөрчлөх, үйл

ажиллагааны зорилго, чиглэлийг тогтоох асуудлыг энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчимд нийцүүлэн Засгийн газар шийдвэрлэнэ.

6.5.Эдийн засгийн тусгай бүсийг төрөл, чиглэлээс хамааран 20 жилээс багагүй хугацаатай байгуулж болно.

6.6.Энэ зүйлийн 6.4-т заасан хугацааг чөлөөт бүсийн үйл ажиллагааны чиглэл, хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамааран дахин нэг удаа сунгах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

6.7.Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу хил залгаа улстай эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулж болох бөгөөд уг чөлөөт бүсэд баримтлах бодлого, чиглэл, тэдгээрийг хил дамнасан байгууламжаар холбох асуудлыг холбогдох улстай байгуулсан гэрээгээр зохицуулна.

6.8.Чөлөөт бүсийн үйл ажиллагааг нээх, түр хаах асуудлыг Чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор Засгийн газар шийдвэрлэнэ.

6.9.Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн үйл ажиллагааг нээх, түр хаах асуудлыг энэ хуулийн 6.7-д зааснаас гадна хил залгаа улстай байгуулсан олон улсын гэрээ, холбогдох хууль тогтоомжид заасан нөхцөл бий болсон тохиолдолд дипломат шугамаар шийдвэрлэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ЧӨЛӨӨТ БҮСИЙН УДИРДЛАГА

7 дугаар зүйл.Чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

7.1.Эдийн засгийн тусгай бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.Эдийн засгийн тусгай бүсийн талаар төрөөс баримтлах бодлого, чиглэлийг боловсруулах;

7.1.2.Эдийн засгийн тусгай бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах, нэгтгэх, бүсийн байршил, хилийн цэсийг тогтоох, өөрчлөх, бүсийн үйл ажиллагааны төрөл, чиглэлийг тодорхойлох, бүсэд олгох газар нутгийн хэмжээний талаар санал боловсруулах;

7.1.3.Эдийн засгийн тусгай бүсийн үйл ажиллагаатай холбоотой төрийн үйлчилгээ, зөвшөөрөл, бүртгэлийг энэ хуульд заасан журмын дагуу хэрэгжүүлэх, шийдвэр гаргах;

7.1.4.Эдийн засгийн тусгай бүсийн үйл ажиллагааны хэрэгжилтийг жил бүр Засгийн газарт тайлагнах;

7.1.5.Эдийн засгийн тусгай бүсийн талаарх төрийн зохицуулалт, үйл ажиллагаатай холбоотой төсвийг боловсруулах;

7.1.6.Эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн асуудлаар төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, төрийн зарим чиг үүргийг хуульд, эсхүл гэрээнд заасны дагуу шилжүүлэн авсан этгээд, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах;

7.1.7.олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, хамтран ажиллах, чөлөөт бүсэд зээл, тусламжаар хэрэгжих төсөл, хөтөлбөрийг удирдлагаар хангаж, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих;

7.1.8.Эдийн засгийн тусгай бүсийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах, тэдгээрийн биелэлтэд хяналт тавих;

7.1.9.Эдийн засгийн тусгай бүсийн үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмыг батлах;

7.1.10.энэ хуулийн 21.1-д заасан Хөрөнгө оруулагчдын зөвлөлөөс санал болгосон төсөл, хөтөлбөрийг сонгон шалгаруулахад тавих шалгуур үзүүлэлтийг тогтоох.

7.1.11.Эдийн засгийн тусгай бүсийн нэгдсэн захиргааны үйл ажиллагааг бодлого, арга зүйн удирдлагаар хангах, бүтэц, зохион байгуулалтын саналыг боловсруулах;

7.1.12.Эдийн засгийн тусгай бүсийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг төвлөрүүлэн бүрдүүлэх, мэдээллийн сангийн хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг хангах, сангаар дамжуулан төрийн байгууллагатай харилцан мэдээлэл солилцох журмыг батлах.

8 дугаар зүйл.Эдийн засгийн тусгай бүсийн нэгдсэн захиргаа

8.1.Эдийн засгийн тусгай бүс нь төрийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, чөлөөт бүсийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хөрөнгө оруулагчдад үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий бие даасан, өөрийгөө санхүүжүүлэх Эдийн засгийн тусгай бүсийн нэгдсэн захиргаа /цаашид “нэгдсэн захиргаа” гэх/-тай байна.

8.2.Засгийн газар нь нэгдсэн захиргааны бүтэц, дүрмийг батлах бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу төр, хувийн хэвшлийн хосолсон загвар бүхий менежментийн компани, эсхүл аж ахуйн тооцоот хуулийн этгээдийн хэлбэрээр байгуулж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ЧӨЛӨӨТ БҮС ДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ДЭГЛЭМ

9 дүгээр зүйл.Чөлөөтбүс дэх үйл ажиллагааны тусгай дэглэмийн зохицуулалт

9.1.Чөлөөт бүсэд гаалийн, визийн, Монгол Улсын иргэн болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн зорчих, хуулийн этгээдийн бүртгэлийн, валют зохицуулалтын, хяналтын, хөдөлмөр эрхлэлтийн, татварын болон бусад тусгай дэглэм үйлчилнэ.

9.2.Чөлөөт бүс дэх төрийн үйлчилгээ нь худалдаа, татварын харилцаа, бизнес, хөрөнгө хөрөнгө оруулалт, захиргааны үйл ажиллагааг хөнгөвчлөх цахим нэг цонхны үйлчилгээнд суурилна.

10 дугаар зүйл.Чөлөөт бүс дэх гаалийн тусгай дэглэм

10.1.Барааг чөлөөт бүсэд оруулахад дараах баримт бичгийг үндэслэн гаалийн бүрдүүлэлт хийнэ:

10.1.1.хилийн чанадаас чөлөөт бүсэд оруулах бараанд ачааны манифест, тээврийн баримт бичиг, шаардлагатай тохиолдолд холбогдох зөвшөөрөл;

10.1.2.Монгол Улсын нутаг дэвсгэрээс чөлөөт бүсэд оруулах бараанд энэ хуулийн 10.1.1-д заасан баримт бичгээс гадна татвар төлсөн баримт.

10.2.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн³ 38.1.4-т зааснаас гадна зорчигчийн худалдан авсан 5.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт хийнэ.

10.3.Хилийн чанадаас чөлөөт бүсэд оруулах, чөлөөт бүсээс хилийн чанадад гаргах бараанд тарифын бус хязгаарлалт тогтоохгүй.

10.4.Барааг хилийн чанадаас чөлөөт бүсэд оруулах, чөлөөт бүсээс хилийн чанадад гаргахад гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт хийнэ.

10.5.Чөлөөт бүсэд нэвтрүүлж байгаа бараанд эрсдэлд суурилсан гаалийн хяналтыг тавина.

10.6.Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь гаалийн байгууллагатай цахим мэдээллийн сүлжээнд холбогдсон байх бөгөөд чөлөөт бүсэд нэвтрүүлсэн барааны бүртгэлийг цахим хэлбэрээр хөтөлнө.

11 дүгээр зүйл.Чөлөөт бүс дэх визийн тусгай дэглэм

11.1.Хилийн зурваст байрлалтай чөлөөт бүсэд хил залгаа улсын иргэн 30 хоногийн хугацаагаар визгүй, гуравдагч улсын иргэн харилцан зорчих нөхцөлийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээний дагуу зорчино.

11.2.Монгол Улсад оршин суух зөвшөөрөлтэй болон "орох-гарах" визтэй гадаадын иргэн оршин суух болон визийн байх хугацаанд аль ч чөлөөт бүсэд визгүй зорчино.

³Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2008 оны 23 дугаарт нийтлэгдсэн.

11.3.Энэ хуулийн 11.1-д заасан гадаадын иргэн, харьяалалгүй хүний визийн байх хугацаа болон визгүй зорчих хугацааг нэг удаад 30 хүртэл хоногоор сунгаж болно.

11.4.Монгол Улсын иргэн болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн чөлөөт бүсэд дараах баримт бичгийн аль нэгийг шалгуулан нэвтэрнэ:

11.4.1.Монгол Улсын иргэн гадаад паспорт, иргэний үнэмлэх, эсхүл жолооны үнэмлэх;

11.4.2.гадаадын иргэн, харьяалалгүй хүн гадаад паспорт, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;

11.4.3.Монгол Улсын 16 насанд хүрээгүй иргэн төрсний гэрчилгээ, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг.

12 дугаар зүйл.Чөлөөт бүс дэх хуулийн этгээдийн бүртгэлийн зохицуулалт

12.1.Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгэгдсэн байх бөгөөд чөлөөт бүсийн захиргаанд бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа явуулна.

12.2.Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд энэ хуульд заасан журмын дагуу нэгдсэн захиргаанд цахимаар бүртгүүлнэ.

12.3.Нэгдсэн захиргаа гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын болон хуулийн этгээдийн мэдээллийг мэдээллийн санд бүртгэл үүссэн өлөрт нь оруулна.

12.4.Нэгдсэн захиргаанд бүртгүүлсэн хуулийн этгээд нь бусад хуулийн этгээдтэй гэрээний үндсэн дээр хамтран ажиллаж хамтран ажиллаж буй хуулийн этгээдийн мэдээллийг энэ зүйлийн 12.1-д заасны дагуу бүртгүүлнэ.

12.5.Нэгдсэн захиргаа чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийг дараах үндэслэлээр чөлөөт бүс дэх хуулийн этгээдийн бүртгэлээс хасна:

12.5.1.хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж, чөлөөт бүс дэх хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээ олгосон өдрөөс хойш нэг жилийн хугацаанд гэрээ, дүрэмд заасан үндсэн үйлдвэрлэл, үйлчилгээг эхлүүлээгүй;

12.5.2.үйл ажиллагаагаа эхлүүлсэн боловч дараалсан 12 сараас дээш хугацаагаар үйл ажиллагаа нь өөрөөс хамаарах шалтгаанаар тасалдсан, зогссон;

12.5.3.татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан.

13 дугаар зүйл.Чөлөөт бүс дэх төлбөр тооцоог гүйцэтгэх зохицуулалт

13.1.Чөлөөт бүсэд төлбөр тооцоог үндэсний болон гадаад валютаар гүйцэтгэнэ.

13.2.Чөлөөт бүсэд төлбөр тооцоог үндэсний болон гадаад валютаар гүйцэтгэх бөгөөд хөрөнгө оруулагч нь хууль ёсны ашиг орлогоо гадаад валютаар саадгүй хил давуулан шилжүүлэх эрхээр хангагдана.

13.3.Гадаад валютын зохицуулалтын ердийн хязгаарлалт тус бүсэд үйлчилэхгүй.

13.4.Чөлөөт бүсэд банк, банк бус санхүүгийн байгууллага, түүний салбар нэгж байгуулахтай холбогдсон харилцааг тухайлсан хуулиар зохицуулна.

14 дүгээр зүйл.Чөлөөт бүс дэх хяналтын зохицуулалт

14.1.Чөлөөт бүсэд дараах үндэслэлээр хяналт шалгалт хийнэ:

14.1.1.гаалийн хяналтын явцад мал, амьтан, ургамал, хорио хяналт, шалгалтад хамаарах бүтээгдэхүүн, түүхий эд, тээврийн хэрэгсэлтэй холбоотойгоор хуульд заасан шалгах шаардлага үүссэн;

14.1.2.чөлөөт бүс доторх бараа бүтээгдэхүүн, хүнсний эрүүл ахуйн чанар, аюулгүй байдал, барилга байгууламжийн чанар, ашиглалтын аюулгүй байдал, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөлтэй холбоотой гомдол ирсэн;

14.1.3.эрсдлийн үнэлгээ, тандалт, судалгааны дүнгээр тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагаа нь хүний эрүүл мэнд, байгаль орчин, олон нийтийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх бодит эрсдэлтэй гэж дүгнэгдсэн;

14.2.Энэ зүйлийн 14.2-т заасан хяналт шалгалтыг Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ.

14.3.Нэгдсэн захиргаа хяналт шалгалтыг зохион байгуулахад холбогдох төрийн байгууллагатай хамтран дэмжлэг үзүүлж, мэдээллээр хангана.

15 дугаар зүйл.Чөлөөт бүс дэх хөдөлмөр эрхлэлтийн тусгай дэглэм

15.1.Чөлөөт бүс дэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэн гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил, үйлчилгээ эрхлүүлсэн, бол ажлын байрын төлбөрөөс бүрэн чөлөөлөгдөнө.

15.2.Чөлөөт бүсэд ажиллаж байгаа хуулийн этгээд өөрийн ажилтныг чадваржуулах, мэргэшүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн тохиолдолд зардлыг тухайн жилийн татвар ногдох орлогоос хасаж тооцно.

16 дугаар зүйл.Чөлөөт бүс дэх татварын тусгай дэглэм

16.1.Чөлөөт бүсэд татварын дараах хөнгөлөлт, чөлөөлөлт үйлчилнэ:

16.1.1.хилийн чанадаас чөлөөт бүсэд импортолсон бараанд импортын гаалийн, нэмэгдсэн өртгийн болон онцгой албан татвар ногдуулахгүй;

16.1.2.импортын гаалийн, онцгой болон нэмэгдсэн өртгийн албан татвар төлж гаалийн нутаг дэвсгэрт оруулсан барааг чөлөөт бүсэд оруулахад татвар

ногдуулахгүй бөгөөд гаалийн нутаг дэвсгэрт тухайн татварыг төлсөн баримтыг үндэслэн бусад татвараас хасалт хийж буцаан олгох;

16.1.3.монголын барааг гаалийн нутаг дэвсгэрээс чөлөөт бүсэд оруулахад нэмэгдсэн өртгийн албан татварыг “0” хувь хэмжээгээр ногдуулах;

16.1.4.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38.1.4-т зааснаас гадна зорчигчийн худалдаж авсан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх;

16.1.5.энэ хуулийн 16.1.4-т зааснаас бусад барааг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн болон бусад татварыг холбогдох хуулийн дагуу ногдуулах;

16.1.6.барааг чөлөөт бүсээс хилийн чанадад гаргахад татвар ногдуулахгүй;

16.1.7.чөлөөт бүсэд бүртгэлтэй иргэн, хуулийн этгээдийн чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн, борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулахгүй.

16.2.Энэ хуулийн 10.2, 16.1.4-т заасан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааны нэр төрлийн жагсаалтыг Засгийн газар тухай бүр нь баталж болно.

16.3.Энэ хуулийн 10.2, 16.1.4-т заасан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй бараанд онцгой албан татвар ногдох бараа, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд заасан эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн хамаарахгүй.

16.4.Чөлөөт бүсэд энэ хуулийн 16.1-д зааснаас гадна дараах татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үйлчилнэ:

16.4.2.чөлөөт бүсэд баригдаж бүртгэгдсэн барилга байгууламжийг үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас бүрэн чөлөөлөх.

16.4.3.чөлөөт бүсэд ногоон хөгжил, инновац, дэвшилтэт технологи, дижиталд суурилсан үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгж нь үйл ажиллагаагаа эхэлснээс хойш таван жилийн хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас 100 хувь чөлөөлөх.

16.5.Чөлөөт бүсэд бүртгэлтэй хуулийн этгээд нь санхүү, татварын тайлангаа татварын хууль тогтоомжид заасан журмын дагуу харьяа татварын албанд тайлагнана.

17 дугаар зүйл.Чөлөөт бүс дэх тусгай дэглэмийн болон бусад үйлчилгээний зохицуулалтыг хэрэгжүүлэх

17.1.Чөлөөт бүсийн нэгдсэн захиргаа улсын бүртгэл, татвар, гааль, шалган нэвтрүүлэх, хорио цээрийн дэглэмийг хэрэгжүүлэх ажлыг тухайн төрийн захиргааны

байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр тэдгээрийн төлөөллөөр дамжуулан хэрэгжүүлнэ.

17.2.Чөлөөт бүсийн нэгдсэн захиргаа нийгмийн хэв журам сахиулах, галын аюулаас хамгаалах, эмнэлгийн яаралтай тусламж, эрүүл ахуй болон дэд бүтцийн хангалтын үйлчилгээ зэргийг тухайн асуудал хариуцсан төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр болон төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.

17.3.Чөлөөт бүсийн нэгдсэн захиргаа энэ хуулийн 17.2-т заасан үйл ажиллагааны хэрэгжилтийн талаарх мэдээллийг холбогдох байгууллагад хууль тогтоомжид заасны дагуу гаргаж өгнө.

ТАВДУГААР БҮЛЭГ

ЧӨЛӨӨТ БҮСЭД АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ

18 дугаар зүйл.Чөлөөт бүсэд эрхлэх үйл ажиллагааны төрөл

18.1.Чөлөөт бүсэд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулиар тогтоосон шаардлагад нийцсэн үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал, худалдаа, олон улсын банк, санхүү, төлбөрт таавар, бооцоот тоглоом зэрэг бүх төрлийн үйл ажиллагаа явуулж болно.

18.2.Энэ 18.1-д заасан үйл ажиллагааг хялбаршуулсан журмаар, цахимаар явуулна.

18.3.Чөлөөт бүсэд явуулах үйл ажиллагаанд дараах чиглэл хамаарна:

- 18.3.1.байгаль орчин;
- 18.3.2.банк, банкнаас бусад санхүүгийн үйлчилгээ;
- 18.3.3.барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуй;
- 18.3.4.дэд бүтэц;
- 18.3.5.зам, тээвэр;
- 18.3.6.санхүү, эдийн засаг, гааль, хөрөнгө оруулалт;
- 18.3.7.соёл, боловсрол;
- 18.3.8.харилцаа холбоо, мэдээлэл технологи;
- 18.3.9.хөдөлмөр эрхлэлт;
- 18.3.10.хууль зүйн болон нийтлэг бусад асуудал;
- 18.3.11.хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр;
- 18.3.12.эрүүл мэнд;
- 18.3.13.эрчим хүч.

18.4.Энэ зүйлийн 18.3-т заасан чиглэлийн үйл ажиллагааны зөвшөөрлийг тухайлсан хуульд заасан тавигдах нөхцөл, шаардлагын дагуу эдийн засгийн тусгай бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

18.5.Тусгай бүсэд бүртгэлтэй хуулийн этгээд энэ зүйлийн 18.3-т заасан чиглэлээр зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагаа явуулах хуульд заасан тавигдах шаардлагыг цахимаар эдийн засгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гаргана.

18.6.Эдийн засгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлнэ.

18.7.Эдийн засгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага энэ зүйлийн 18.6-д заасан хүсэлт, баримт бичгийн бүрдлийг хүсэлт хүлээн авснаас хойш ажлын 2 өдрийн дотор тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахимаар хүргүүлнэ.

18.8.Энэ зүйлийн 18.7-д заасан төрийн захиргааны төв байгууллага холбогдох баримт бичгийг ажлын 3 өдрийн дотор магадлан шалгаж, холбогдох саналаа цахимаар хүргүүлнэ.

18.9.Тухайн салбарын асуудал хариуцсан төрийн байгууллага энэ зүйлийн 18.8-д заасан хугацаанд саналаа ирүүлээгүй бол саналгүйд тооцож, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

18.10.Энэ зүйлийн 18.4-т заасан этгээд зөвшөөрөл олгох эрхээ бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 7.1.7-д заасан хуулийн этгээдэд шилжүүлж болно.

18.11.Энэ зүйлийн 18.9-д заасан шийдвэрийг Зөвшөөрлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 5-д заасан журмын дагуу Зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд хүргүүлнэ.

19 дүгээр зүйл.Чөлөөт бүсийн аж ахуйн үйл ажиллагааны орлого

19.1.Чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба дараах орлогыг улсын төсөвт төвлөрүүлнэ:

19.1.1.чөлөөт бүс дэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэний орлогын албан татвар, тэдгээрээс авах хураамж;

19.1.2.чөлөөт бүсийн төрийн өмчийн барилга байгууламжийг эзэмшиж, ашигласны болон үйлчилгээ үзүүлсний төлбөр;

19.1.3.дуудлага худалдаа болон төсөл сонгон шалгаруулах журмаар олгосон газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний төлбөр.

19.1.4.газрын төлбөр;

19.1.5.бусад аж ахуйн ажил, үйлчилгээний орлого.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасан орлогын 20 хүртэл хувийг чөлөөт бүсийг хөгжүүлэх, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг түргэтгэх, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор зарцуулна.

20 дугаар зүйл.Эдийн засгийн тусгай бүсийн нэгдсэн захиргаанаас орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргатай харилцах

20.1.Нэгдсэн захиргаа нь орон нутгийн хүн амын хөдөлмөр эрхлэлт, амьжиргааны түвшинг дээшлүүлэх асуудалд тухайн чөлөөт бүсийг хөгжүүлэх

асуудлаар орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргатай хамтран ажиллана.

20.2.Орон нутгийн хүн амын хөдөлмөр эрхлэлт, амьжиргааны түвшинг дээшлүүлнэ.

20.3.Чөлөөт бүс, аймаг, орон нутгийн нийтлэг ач холбогдолтой үйлдвэрлэлийн дэд бүтцийг байгаль орчинд ээлтэй байхаар хөгжүүлэх төсөл, арга хэмжээг хамтран хэрэгжүүлнэ.

21 дүгээр зүйл.Хөрөнгө оруулагчдын зөвлөл

21.1.Чөлөөт бүс нь хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө оруулагчдын эрх ашиг сонирхлыг хамгаалах, чөлөөт бүсийн хөгжлийг дэмжих, сурталчлах зорилго бүхий хөрөнгө оруулагчдын төлөөлөгчдөөс бүрдсэн Хөрөнгө оруулагчдын зөвлөлтэй байна.

21.2.Хөрөнгө оруулагчдын зөвлөл нь чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын төлөөллөөс бүрдэх бөгөөд холбогдох төрийн байгууллагын төлөөлөл зөвлөлийн үйл ажиллагаанд бодлогын мэдээлэл өгөх, зөвлөх байдлаар оролцоно.

21.3.Хөрөнгө оруулагчдын зөвлөл нь хурлаараа баталсан дүрмээр үйл ажиллагаагаа зохицуулна.

21.4.Хөрөнгө оруулагчдын зөвлөл нь чөлөөт бүсийн менежмент, бодлого, зохицуулалтын талаар санал, зөвлөмж гарган чөлөөт бүсийн нэгдсэн захиргаанд хүргүүлнэ.

21.5.Хөрөнгө оруулагчдын зөвлөл нь тусгай бүсэд үйл ажиллагаа явуулж буй дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын төлөөллөөс бүрдэх бөгөөд холбогдох төрийн байгууллагын төлөөлөл зөвлөлийн үйл ажиллагаанд бодлогын мэдээлэл өгөх, зөвлөх байдлаар оролцоно.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ ЧӨЛӨӨТ БҮС ДЭХ ГАЗРЫН ХАРИЛЦАА

22 дугаар зүйл.Газрын зохицуулалт

22.1.Чөлөөт бүсийн газар нь боомтын газар нутагт хамаарахгүй.

22.2.Чөлөөт бүс доторх газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах шийдвэрийг чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргаж, нэгдсэн захиргаа газар ашиглагчтай гэрээ байгуулах бөгөөд уг шийдвэрт ашиглах газрын хэмжээ, хугацааг тусгасан байна.

22.3.Чөлөөт бүсэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглуулах газрын суурь үнэлгээ болон газрын төлбөрийн хэмжээг Засгийн газар тогтооно.

22.4.Газар ашиглах эрхийг төсөл сонгон шалгаруулах, дуудлага худалдааны аль нэг хэлбэрийг ашиглан олгоно.

22.5.Чөлөөт бүсэд газар ашиглуулах эрхийг төсөл сонгон шалгаруулалтаар авсан хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу итгэлцүүрээр тогтоосон дуудлага худалдааны анхны үнэтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн төлбөрөө төлсний дараа газар ашиглуулах эрхийн гэрчилгээ олгоно.

22.6.Энэ хуулийн 12.5.1, 12.5.2-т заасан нөхцөл байдал үүссэн аж ахуйн нэгжийн газар ашиглах эрхийг хүчингүй болгоно.

22.7.Чөлөөт бүсэд газар ашиглуулахтай холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Газрын тухай хуулиар⁴ зохицуулна.

23 дугаар зүйл.Газрын төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлт

23.1.Чөлөөт бүсэд худалдаа, аялал жуулчлал, зочид буудлын үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс чөлөөт бүсэд ашиглаж байгаа газрын төлбөрөөс эхний таван жилд 100 хувь, дараагийн гурван жилд 50 хувиар хөнгөлнө.

23.2.Чөлөөт бүсэд эрчим хүч, дулааны эх үүсвэр, шугам сүлжээ, цэвэр усан хангамж, ариутгах, цэвэрлэх байгууламж, авто зам, төмөр зам, нисэх онгоцны буудал, харилцаа холбооны үндсэн сүлжээ зэрэг дэд бүтэц болон үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгж, түүний салбарыг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс чөлөөт бүсэд ашиглаж байгаа газрын төлбөрөөс эхний 10 жилд 100 хувиар чөлөөлнө.

23.3.Чөлөөт бүсэд газар ашиглах гэрээ байгуулж, бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлж буй хуулийн этгээдийг гэрээ байгуулснаас хойш эхний таван жилийн хугацаанд газрын төлбөрөөс 100 хувь, дараагийн таван жилийн хугацаанд 50 хувиар чөлөөлнө.

23.4.Энэ хуулийн 23.3-т заасан газрын төлбөрөөс хөнгөлөх хугацаа, хувь хэмжээг тогтоох асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ ЧӨЛӨӨТ БҮСИЙН ДЭД БҮТЭЦ

24 дүгээр зүйл.Чөлөөт бүсийн дэд бүтэц, барилга байгууламж

24.1.Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд заасны дагуу чөлөөт бүсийн хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөг Засгийн газар батална.

24.3.Энэ зүйлийн 24.1-д заасан төлөвлөгөөний дагуу төрөлжүүлэн байгуулсан чөлөөт бүсийн жилийн төлөвлөгөөг чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

24.4.Чөлөөт бүсийн дэд бүтэц, барилга байгууламжийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний үндсэн дээр байгуулж болно.

⁴ Газрын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 27 дугаарт нийтлэгдсэн.

24.5.Чөлөөт бүсийн дэд бүтцийг энэ хуулийн 24.3-т зааснаас гадна улсын болон орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламж болон Засгийн газрын бондоор санхүүжүүлж болно.

НАЙМДУГААР БҮЛЭГ ЭДИЙН ЗАСГИЙН ТУСГАЙ БҮС ДЭХ МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ

25 дугаар зүйл.Маргаан хянан шийдвэрлэх журам

25.1.Чөлөөт бүсэд үүссэн иргэний, захиргааны хэргийн маргааныг талуудын харилцан тохиролцоонд үндэслэн арбитрын журмаар шийдвэрлэнэ.

25.2.Арбитрын ажиллагааг Арбитрын тухай хуульд заасан журмын дагуу явуулна.

25.3.Талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитрын ажиллагаанд Монгол Улсын эрх зүйг хэрэглэнэ.”

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ЧӨЛӨӨТ БҮСИЙН ХАРУУЛ ХАМГААЛАЛТ

26 дугаар зүйл.Чөлөөт бүсийн хамгаалалт

26.1.Чөлөөт бүс нь улсын онцгой объектод хамаарна.

26.2.Хилийн зурвас дахь чөлөөт бүсийн харуул хамгаалалтын үүргийг хил хамгаалах байгууллага, бусад чөлөөт бүсийн харуул хамгаалалтын үүргийг холбогдох байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр тус тус гүйцэтгэнэ.

26.3.Чөлөөт бүсэд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг цагдаа, дотоодын цэрэг гүйцэтгэнэ.

АРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

27 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

27.1.Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэн нь чөлөөт бүсийн нэгдсэн захиргаатай байгуулсан гэрээний хугацаа дуусгавар болохоос өмнө дампуурснаас бусад шалтгаанаар татан буугдсан буюу чөлөөт бүс дэх үйл ажиллагаагаа зогсоосон тохиолдолд хөнгөлж, чөлөөлсөн татварын хувь хэмжээний нийлбэрээр тухайн аж ахуйн нэгжийн татварын өрөнд шилжүүлэн тооцно.

27.2.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

27.3.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 10 дугаар зүйлд доор дурдсан дараах хэсэг нэмсүгэй:

“5.Засгийн газар эдийн засгийн хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын стратегитай уялдуулан чөлөөт бүс, эдийн засгийн чөлөөт бүс байгуулах, тэдгээрийн дэд бүтэц, удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, төрийн байгууллагын уялдаа холбоог ханган ажиллана.

6.Эдийн засгийн бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газар чөлөөт бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах, түүний хилийн цэс, байршлыг тогтооно.

2 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 1 дэх заалтын “-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал” гэсний дараа “-чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт.” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 2 дахь заалтын “-чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт;” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Эдийн засгийн тусгай бүсийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дугаар зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт доор дурдсан агуулгтай 4.10 дахь заалт нэмсүгэй:

“4.10.чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт үйлчлэх тусгай дэглэм, зөвшөөрөл олгохтой холбогдох харилцаа.

2 дугаар зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.21 дэх заалт, мөн зүйлийн 12.13 дахь заалт, 8.2 дугаар зүйлийн 1.9 дэх заалт, мөн зүйлийн 11.6 дахь хэсэг, “, эсхүл чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч” гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Эдийн засгийн тусгай бүсийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дугаар зүйл. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийн “, чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “, чөлөөт бүсэд чөлөөт бүсийн захирагч” гэснийг, 15¹ дүгээр зүйлийн 15^{1.1} дэх хэсгийн “, эсхүл чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагчид” гэснийг, 15^{1.3} дахь хэсгийн “, эсхүл чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагчийн” гэснийг 15^{1.4} дэх хэсгийн “, эсхүл чөлөөт бүсийн захирагч” гэснийг, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “, чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч,” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “, чөлөөт бүсийн захирагч” гэснийг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “, чөлөөт бүсийн захирагч” гэснийг, 35 дугаар зүйлийн 35.1.2 дахь заалтын “, чөлөөт бүсийн захирагч” гэснийг, 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийн “чөлөөт бүс,” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Эдийн засгийн тусгай бүсийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дугаар зүйл. Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсгийн “чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Эдийн засгийн тусгай бүсийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХАРХОРУМ ХОТЫН ТӨЛӨВЛӨЛТ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дугаар зүйл.Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “чөлөөт бүс” гэснийг “эдийн засгийн тусгай бүс” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Эдийн засгийн тусгай бүсийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хот байгуулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.1.8 дахь заалт нэмсүгэй:

“6.1.8.чөлөөт бүс, эдийн засгийн чөлөөт бүсийн хилийн цэс, байршлыг баталж, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах.”

2 дугаар зүйл. Хот байгуулалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалт, 11.5.1 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтын “чөлөөт бүс,” гэснийг, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “Чөлөөт бүс,” гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Эдийн засгийн тусгай бүсийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХОТ, ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Эдийн засгийн тусгай бүсийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг